**БУЛГАН АЙМГИЙН**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг. 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2023.05.19 № 345

танай ______________ ны № ______________ т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ГҮЙЦЭТГЭЛ НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд, аймгийн Төрийн аудитын газрын 2023 оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний дагуу "Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтиын тогтолцоо, үр нөлөө"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хүргүүлэв.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.ЭРДЭНЭ

006030412

D/bichig hereg/2023/A5toot

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

***АУДИТЫН СЭДЭВ "ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО, ҮР НӨЛӨӨ"***

**АУДИТЫН КОД: БУА-2023/19-4-ШТА-ГА**

**БУЛГАН АЙМАГ**
**2023 ОН**


Булган дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ
Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Анхбаяр
Утас: 7034-2495 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn
Аудитор: А.Сувдаа
Утас: 7034-2495 Цахим хаяг: Suvdaaa@audit.gov.mn
Аудитор: Б.Энхтөр
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn
Аудитор: Б.Золжаргал
Утас: 7034-2495 Цахим хаяг: Zoljargalb@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
bulgan@audit.gov.mn

**БУЛГАН АЙМГИЙН**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН**
**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 05 сарын 19 өдөр    Дугаар А/09    Булган сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын "Эрх, үүрэг шилжүүлэх тухай" 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалт, А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө"-д хийсэн шууд тайлагнах аудитын тайланг (БУА-2023/19-4-ШТА-ГА) баталсугай.

2. ."Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө"-өөр илэрсэн алдаа, зөрчлийг нэг дүгээр хавсралтаар баталсугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт, үр дүнг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хариу ирүүлэхийг аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга (Б.Ариунболд)-д зөвлөсүгэй.

4.Аудитын зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг тооцож ажиллахыг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор гаргаж танилцуулахыг ахлах аудитор (Д.Анхбаяр), аудитын менежер (Ж.Энхцоодол) нарт үүрэг болгосугай.

5.Аудитын тайланг ҮАГ-ын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэст тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР    Б.ЭРДЭНЭ

D: /bnchig hereg/2023/tushaal/TAtushaal.doc

006010026

**Агуулга**

Товчилсон үгийн тайлбар....3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээлэл....4
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:....5
БҮЛЭГ А. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангалттай байна....7
А.1.1. Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангагдсан байна....7
А.1.2. Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл хууль тогтоомж, дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн байна....8
А.1.3. Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллаж байгаа боловч тогтолцоог сайжруулах шаардлагатай байна....9
БҮЛЭГ.Б. Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлж байна.9
Б.1.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг зохих ёсоор хянаж, гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй байх эрсдэлтэй байна....10
Б.1.3. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь 2 орон тоо дутуу ажиллаж байна...11
Б.1.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулалт ил тод байдлыг хангасан байна....11
Б.1.6. Төр, хувийн хэвшлийн байгууллагуудын үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зарим зардлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэж олгоогүй байна....14
Б.2.1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд тусламж үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэхээр заасан боловч зарим иргэдийг бүрэн хамруулаагүй, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар үр дүнтэй ажил зохион байгуулаагүй байна....17
Б.2.2.Хуульд заасны иргэдийг мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагуудын уялдаа холбоог хангасан цахим системийн хөгжүүлэлт хангалтгүй байна....17
Б.2.3.Эрүүл мэндийн байгууллага болон иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд үр дүнтэй шийдвэрлээгүй байна....18
Б.3.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлд зохих хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж тавиагүй байх....19
Б.3.3. Эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй нь тус ЭМДХ-ийн үйл ажиллагаа, хяналт хууль журмын дагуу явуулаагүй байх эрсдэлтэй байна....20
Б.3.4. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлыг ЭМДЕГ-аас шийдвэрлэдэг байна....20
ДҮГНЭЛТ 20
ЗӨВЛӨМЖ: АУДИТЫН ДҮН, ДҮГНЭЛТ НОТЛОХ ЗҮЙЛСТ ҮНДЭСЛЭН ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ ӨГЧ БАЙНА....22

Хүснэгт 1. ЭМДХ-ийн 2021, 2022 оны санхүүжилт....10
Хүснэгт 2. ЭМДХ-ийн 2021, 2022 оны хамрагдалт....17

График 1....10
График 2....14
График 3....16

*Хавсралт 1* ........ 23
*Хавсралт 2* ........ 23
*Хавсралт 3* ........ 24
*Хавсралт 4* ........ 25
*Хавсралт 5* ........ 25

**Товчилсон үгийн тайлбар**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| НДЕГ | Нийгмийн даатгалын ерөнхий газар |
| НДХ | Нийгмийн даатгалын хэлтэс |
| ТАБ | Төрийн аудитын байгууллага |
| УИХ | Улсын Их Хурал |
| ЭМДЕГ | Эрүүл мэндийн ерөнхий газар |
| ЭМДҮЗ | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны "Аудитын сэдэв батлах тухай" 2022 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

**Аудитын зорилго**

"Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө" сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

**Аудитын хамарсан хүрээ**

Аудитад аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, өрх, сум, багийн эрүүл мэндийн төвүүд, эрүүл мэндийн хөгжлийн төв болон Нийгмийн даатгалын хэлтсийн 2021-2022 оны үйл ажиллагааг хамруулсан.

Шүүхийн шийдвэртэй, хууль хяналтын байгууллагад шалгагдаж буй асуудлыг аудитад хамруулаагүй болно.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, Нийцлийн аудитын холбогдох стандартад заасан арга зүйг ашиглан салбарын бодлого, тогтолцоо, үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухай асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж боловсруулав.

**Аудитын бүрэлдэхүүн, хугацаа**

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Анхбаяр, аудитор А.Сувдаа,

Б.Энхтөр, Б.Золжаргал нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Аудитын талбарын үе шатны ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 17-ний өдрөөс эхлэн гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс эхлүүлнэ. Аудитын тайланг 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Үндэсний аудитын газарт болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь 2022 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилгын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Монгол хүн бүрийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, даатгалын тогтвортой санг бүрдүүлэн, даатгуулагчийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг худалдан авдаг үйлчлүүлэгч төвтэй, нийгмийн хариуцлага бүхий менежментийг хэрэгжүүлэхэд оршино.

Нэг. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, даатгалын хамралтыг нэмэгдүүлнэ.

Хоёр. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон санхүүгийн шалгуур үзүүлэлтийн дагуу хяналтыг хэрэгжүүлнэ.

Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

Стратеги төлөвлөгөөний зорилго 3. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах

Нэг. Иргэд, даатгуулагчдад салбарын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг мэдээлэх, бусад байгууллагуудтай хамтран ажиллах, даатгалын сургалт, сурталчилгааг хийнэ.

Хоёр. Бусад байгууллагуудтай хамтран ажиллах

Булган аймаг нь 62000 хүн амтай, 16 сум, 1 тосгонтой. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай улсын 1, хувийн хэвшлийн 2, рашаан сувилал 2, шүдний эмнэлэг 2, сум, тосгоны эрүүл мэнд төв 16, өрхийн эрүүл мэндийн төв 2, эмийн сан 33 нийт 58 байгууллагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах гэрээ байгуулснаас 3 эмийн сан хөнгөлөлттэй эмээр үйлчлээгүй, гүйцэтгэл ирүүлээгүй, 53 байгууллагын нэхэмжлэлийг хянасан байна.

ЭМДЕГ-ийн хэмжээнд газар хэлтсүүдийн дунд үйл ажиллагаанд "Бүтээмж чанарыг сайжруулах"-ын тулд 2022 оны сүүлийн хагас жилд "Сайн туршлага аян"-ны болзолт уралдаан зарласан бөгөөд шалгарсан сайн туршлагыг хэлтэс дээрээ хэрэгжүүлэн ажиллах үүрэг чиглэл өгсний дагуу 5 аймгийн сайн туршлагыг хэрэгжүүлэн ажиллаж тайлан мэдээг цаг тухай бүрд нь хүргүүлэн ажиллаж төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай байна.

Edaatgal гар утасны аппликейшныг иргэдийн гар утсанд суулгах, ач холбогдлыг сурталчлах ажлыг эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарч зохион байгуулан ажилласан байна.

Уг аппликейшныг 766 хүн ашиглаж байна. Сурталчилгааны материал 5 төрлөөр хэвлүүлэн гэрээт 49 байгууллага НДХ болон 15 сум, 1 тосгоны НД-ын байцаагчид өгч иргэдэд мэдээлэл өгөн ажиллаж, шинээр 2022 оны 04 дүгээр сарын 21-нд page хуудас нээсэнд дагагч 172 хандалтын тоо 11525 хүн байна.

**БҮЛЭГ А. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангалттай байна.**

***А.1.1. Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангагдсан байна.***

Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх 8 зорилт, Булган аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх 3 зорилт арга хэмжээг тусган хэрэгжилт тооцон ажиллажээ.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 02/05 дугаар тогтоолоор баталсан " Булган аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл"-д нийт 3 зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 1.2-т заасан "*Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлж эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж, үр дүнтэй тогтолцоог бэхжүүлэх" 1.2.1-д Эрүүл мэндийн салбар орчин үеийн стандартад нийцсэн барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжөөр хангагдан эмчилгээ, оношлогооны шинэ технологи нэвтэрч, үйлчилгээний нэр төрөл олширсон байна. 1.2.2-т Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсрол дээшилж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бэхжүүлэх замаар халварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэх үзлэг, оношлогоо шинжилгээнд иргэдийг бүрэн хамруулсан байна. 1.2.3-т Эрүүл мэндийн байгууллагууд шаардлагатай хүний нөөцөөр бүрэн хангагдаж, тэднийг чадавхжуулах, өндөр хөгжилтэй оронд сурах боломж бүрдэн, нийгмийн баталгаа хангагдана. зэрэг* арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган хэрэгжилтийг тооцон ажиллаж, зорилтийн биелэлт 86 хувьтай байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 02/04 дугаар тогтоолоор баталсан "Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр-2020-2024"-т нийт 8 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс тус хөтөлбөрийн 1.1-т заасан 8 арга хэмжээний хэрэгжилт 87,3 хувьтай байна.

"Алсын хараа-2050 МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын I үе шат (2021-2030): Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийн үе шатанд:

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар гүйцэтгэлд тулгуурласан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлж эхэлснээр иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ нэмэгдсэн. Сумын Эрүүл мэндийн төвүүд энэ цахим системд холбогдсоноор хуучин 4 үйлчилгээг үзүүлдэг байсан бол энэ онд шинээр 4 төрлийн тусламж үйлчилгээг нэмж үзүүлэх боломжтой болсон байна.
2. Эрт илрүүлгийн улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар 36 хувьтай байгаа бөгөөд эрт илрүүлгийг зохион байгуулснаар халдварт өвчлөлөөс 25 хувиар урьдчилан сэргийлсэн үзүүлэлтэй байна.

Монгол улсын ЗГ-н тогтоолоор эрт илрүүлгийг 2023 оныг дуустал үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн тул эрт илрүүлгийн арга хэмжээ үргэлжлэн явагдаж байгаа бөгөөд жилийн эцэст 100 хувьд хүргэж ямарваа нэгэн хорт хавдар, өвчнөөс 50 хувь сэргийлэх зорилт тавин ажиллаж байна.

3. ЭМДҮЗ-н тогтоолуудаар Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнүүдийг 70-100 хувь хөнгөлж тухайн иргэн 0-30 хувийн төлбөрийг өөрсдөө төлж байна. .

УИХ-ын 2020 оны 23 тогтоолоор батлагдсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл"-ийн 2.2-т заасан "*Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийх зорилт*"-ын хүрээнд нийт 8 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгаснаас эрүүл мэндийн даатгалтай холбоотой

гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлж, эмнэлгийн хагас бие даасан байдлыг хангаж, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэх замаар улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлж, иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулах, эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэж, өдөр тутмын оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг бүрэн нэвтрүүлэх, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлэн хяналтын тогтолцоог бүрдүүлэх асуудлыг тусгасан байна.

УИХ-ын 2020 оны 24 тогтоолоор батлагдсан "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т нийт 14 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан ба хөтөлбөрийн 2.1-т заасан "*Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт*"-ын хүрээнд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулах, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусган хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Аймгийн Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсээс эрүүл мэндийн салбар хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг жил бүр тооцож 2021 онд 85.4%, 2022 онд 86.6% дүгнүүлсэн байна.

### *А.1.2. Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл хууль тогтоомж, дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн байна.*

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд эрүүл мэндийн даатгалын удирдах дээд байгууллага нь Үндэсний зөвлөл байхаар заасан байна.

Тус хуульд эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн хэрэгжүүлэх 8 үүргийг тусгасан байна. ЭМДҮЗ-ийн үйл ажиллагаанд аймгийн ЭМДХ оролцдоггүй учир дүгнэх боломжгүй бөгөөд гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллажээ.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу эрүүл мэндийн даатгалын удирдах дээд байгууллага Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл нь 2022 онд "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам"-ыг 05 дугаар тогтоолоор "Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ", "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх төлбөрийн арга", "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, хяналт тавих журам"-ыг тус тус баталжээ.

Мөн журам шинэчлэн батлах тухай 02 дугаар тогтоолоор "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам"-ыг, "Эмийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 11 дүгээр тогтоолоор "Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ"-г тус тус шинэчлэн баталж хуульд заасан үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

**А.1.3. Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлж байгаа боловч тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.**

2022 онд ЭМДҮЗ-ийн 02, 05, 06, 11, 12 дугаар тогтоолын дагуу гэрээтэй Эрүүл мэндийн байгууллагуудын сонгон шалгаруулалтыг цахимаар хийж гэрээ байгуулан ард иргэдэд үзүүлсэн үйлчилгээг санхүүжүүлэх, хяналт тавих журмын дагуу хяналтыг хийж санхүүжилтийг олгосноор гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоо Монгол улсад амжилттай хэрэгжиж байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Монгол улсыг гүйцэтгэлд суурилсан эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг олон улсын түвшинд чанартай хурдан, дэлхийн түвшингээс дээгүүр хэрэгжүүлсэн байна гэж дүгнэсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас төлөвлөн Эрүүл мэндийн Яаманд хүргүүлж, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор аймгуудын төсвийн хуваарийг баталж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас төлөвлөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор аймгуудын төсвийн хуваарийг батлан ажиллажээ.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээний дагуу 51 байгууллага Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авах төлбөрийн нэхэмжлэхээ дараа сарын 5-ны өдрийн дотор илгээж, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нэхэмжлэлийн хяналтыг сар бүр түүврийн аргаар хийж байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 05 дугаар тогтоолоор өрх, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх нэг иргэнээр тооцсон тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам баталсан байна.

Хүн ам цөөтэй сумын хувьд нэг иргэнээр тооцсон санхүүжилт нь иргэнд үзүүлж байгаа эмнэлгийн тусламж үйлчилгээ, оношилгооны зардлаас хэтэрдэг нь цаашид сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд хүндрэл учрах эрсдэлтэй байна.

**БҮЛЭГ Б. Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлж байна.**

***Б.1.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын төлөвлөгөөг НДЕГ, ЭМДЕГ-аас баталдаг боловч 2022 онд Засгийн газраас төрийн албан хаагчийн цалин, хөлс нэмэгдэнэ гэсэн шалтгаанаар ЭМД-ын орлогыг өмнөх оноос 2 дахин үндэслэлгүй нэмэгдүүлснээр орлогыг бүрэн төвлөрүүлж чадаагүй байна.***

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг ЭМДЕГ-ын даргын баталсан 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/11 тоот тушаалаар Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран ажиллаж байна.

Булган аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь 2021 онд 16 сум, 1 тосгоны хэмжээнд эрүүл мэндийн даатгалын орлогыг 427,875.16 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 429,583.61 мянган төгрөг төвлөрүүлж 100.4 хувийн гүйцэтгэлтэй орлого бүрдүүлжээ.

Орлогын төлөвлөлтийг Нийгмийн даатгалын Ерөнхий газар болон Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас баталж ирүүлж 2022 онд 860,374.49 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 499,488.0 мянган төгрөг төвлөрүүлж 58.1 хувийн

биелэлттэй, орлогыг 41.9 хувиар буюу 360,886.5 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлжээ.

*График 1*




Орлого тасарсан шалтгаан нь өмнөх онтой харьцуулбал орлогын төлөвлөгөөг 432,500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн нь Засгийн газраас төрийн албан хаагчийн цалин нэмэгдэнэ гэж тооцон орлогын 2 дахин үндэслэлгүй, тушаал шийдвэргүйгээр нэмж төлөвлөсөнтэй холбоотой байна.

### *Б.1.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг зохих ёсоор хянаж, гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй байх эрсдэлтэй байна.*

Аймгийн ЭМДХ программаар олгосон санхүүжилтийн дүнгээр батлагдсан маягтын дагуу санхүүгийн тайланг бэлтгэн ЭМДЕГ-т хүргүүлж нэгтгүүлж ажилласан байна.

Гүйцэтгэл хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт 1. ЭМДХ-ийн 2021, 2022 оны санхүүжилт*

*/Мянган төгрөг/*

| Агуулга | | 2021 он | 2022 он | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Дүн | Хувь |
| Нэхэмжилсэн | Тоо | 252330 | 271892 | 19562 | 8 |
| | Мөнгөн дүн | 17,852,222.67 | 21,381,544.93 | 3,529,322.26 | 19.77 |
| Хасагдсан | Тоо | 11175 | 8845 | (2330) | (21) |
| | Мөнгөн дүн | 1,649,967.67 | 870,816.84 | (779,150.82) | (47.22) |
| | Нэхэмжлэлд эзлэх хувь /тоо/ | 4.43 | 3.25 | (1.18) | (26.54) |
| | Нэхэмжлэлд эзлэх хувь /мөнгөн дүн/ | 9.24 | 4.07 | (5.17) | (55.93) |
| Олговол зохих санхүүжилт | Тоо | 241155 | 263047 | 21892 | 9 |
| | Мөнгөн дүн | 16,202,255.00 | 20,510,728.09 | 4,308,473.09 | 26.59 |

*Эх сурвалж: Аймгийн ЭМДХ-ийн 2021, 2022 оны олгосон санхүүжилтийн нэгтгэлээс*

Дээрх хүснэгтээс харахад 2021, 2022 онд хяналтаар хасагдсан дүн нийт нэхэмжилсэн дүнгийн 9.2, 4.1 хувийг эзэлж өмнөх оноос 47.2 хувиар буурсан байна. Батлагдсан маягтын дагуу санхүүгийн тайланг гаргахдаа алдаатай гаргажээ. Тухайлбал:

- Батлагдсан маягт тайланд ЭМБ-ын өглөг, авлагыг зөрүүлсэн,
- ЭМДЕГ-аас ирүүлсэн тоон мэдээлэл ЭМДХ-ийн тайлангийн дүн зөрүүтэй, тухайлбал "Хульж", "Баатарван" сувиллын нэхэмжилсэн дүн, олгохоор тооцсон дүн зөрүүтэй /Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харах/,
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авахтай холбоотой гэрээнд заасны дагуу алданги тооцож олгосон эсэх талаарх мэдээлэл байхгүй байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авахтай холбоотой гэрээнд заасны дагуу дараах шалтгааны улмаас гүйцэтгэл бодиттой илэрхийлэгдэхгүй байна.

- Зарим ЭМБ, эмийн сангийн хүний нөөцийн хүрэлцээ муу,
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагын эрх бүхий эмчийн нөөц, ур чадвар, программын сургалт дутмагаас гүйцэтгэлийг бодиттойгоор журмын хугацаанд программд алдаатай оруулдаг,
- Цахим программын талаарх сургалт дутмаг,
- Холбогдох эмч албан хаагчийн хариуцлага сулаас онош буруу бүртгэх, программын шинэчлэлийг тухай бүр хийдэггүй,
- Гэрээгээр тус ЭМБ-гийн ор хоногийг баталж өгсөн ч батлагдсан ор хоногоос гүйцэтгэлээр "Баатарван" сувиллын 2021 оны 7, 8, 9 дүгээр сард 6, 872, 350, 2022 оны 7 дугаар сард 370 ор хоногоор илүү гүйцэтгэлтэй,
- Программын газартай ойлголтын зөрүү үүсдэг, холбогдоход хугацаа алдах,
- Хасалт хийсэн шалтгааныг тухай бүр журмын дагуу мэдээлээгүй зэргээс шалтгаалсан байна.

***Б.1.3. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь 2 орон тоо дутуу ажиллаж байна.***

2022 онд бүтэц орон тоогоо Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/10 тушаалаар шинэчлэн баталж Хэлтсийн дарга 1, чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн 3 нийт 4 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

2021 онд тус орон тоогоор баталсан боловч одоогоор ЭМДХ нь дарга, чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн 1 гэсэн 2 орон тоотой ажилласан, ЭМДЕГ-аас хүний нөөцийн судалгааг авч дутагдалтай орон тоон дээр сонгон шалгаруулалт хийхээр төлөвлөсөн байна.

Аймгийн ЭМДХ нь дотоод үйл ажиллагаа болон ЭМДС-ийн санхүүжилтийн гүйлгээ хийдэггүй ЭМДЕГ-аас гүйлгээ хийх эрх олгоогүй хөрөнгө, санхүүжилтийг 100 хувь дээд газраас нь олгон ажиллажээ.

***Б.1.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулалт ил тод байдлыг хангасан байна.***

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 09 дүгээр тогтоолоор "Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам"-ыг баталсан бол 2022 оны 02 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан байна.

Гэрээт Эрүүл мэндийн байгууллагуудын сонгон шалгаруулалтын ажлыг ЭМДЕГ-ын Худалдан авалт гэрээлэлтийн газарт хариуцан хууль, дүрэм журмын дагуу зохион байгуулан ажиллаж байна. ЭМДЕГ-аас цахимаар сонгон шалгаруулалтыг emd.gov.mn цахим хаягаар зарлан аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 16 сумын Эрүүл мэндийн төв, 2 Өрхийн эрүүл мэндийн төв, 30 эмийн сан 2 рашаан сувилал оролцож 2022 онд хамтран ажиллах гэрээг байгуулжээ.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтад аймгийн хэмжээнд 2021 онд 55 байгууллага, 2022 онд 51 байгууллага тэнцэж хувийн хэвшлийн 2 эмнэлэг, 2 эмийн сан хасагдсан байна.

Дээрх байгууллагууд 1818.mn цахим мэдээллийн системээр дамжуулан Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулалтад ордог бөгөөд тус цахим системд сонгогдсон болон сонгогдоогүй байгууллага, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрөл тус бүрээр тэнцсэн, тэнцээгүй шалтгаан нөхцөл нийтэд нээлттэй харагдаж байгаа нь ил тод байдлыг хангасан байна.

Мөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтад тэнцсэн байгууллагын гэрээг 3 жилийн хугацаатай байгуулан тусламж үйлчилгээний нэр төрлийг хавсралтаар жил бүр өөрчлөлт хийдэг байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтад тэнцээгүй түгээмэл шалтгаан нь нарийн мэргэшлийн эмч, ажилтан байхгүйтэй холбоотой байна.

***Б.1.5. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах гэрээг 2021 онд 18 ЭМТ, 28 эмийн сантай гэрээ байгуулж жилийн эцэст гэрээг дүгнэж, 2022 онд ЭМТ, Эмийн сантай гэрээ байгуулсан болович гэрээг дүгнэж, үнэлээгүй байна.***

Булган аймаг нийт 62,000 хүн амтай, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж үйл ажиллагаа явуулж байгаа 16 сум, 1 тосгоны 18 ЭМТ, 30 эмийн сантай.

2021 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээг ЭМДЕГ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн А/03 дугаар тулаалд заасны дагуу гэрээ бүхий 18 ЭМТ-ийн "Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвөөс зарим эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах гэрээ"-г 2022 оны 01 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд дүгнэжээ.

ЭМДЕГ-ын даргын 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/142 дугаар тушаалаар "Даатгалын гэрээ дүгнэх журам"-ыг нэгдүгээр хавсралт, "Даатгалын гэрээ дүгнэх үнэлгээний хуудас"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталжээ.

2021 оны гэрээг "Даатгалын гэрээ дүгнэх журам"-аар дүгнэхэд Хишиг-Өндөр сумын ЭМТ, Могод сумын ЭМТ-үүд 80 хувиар дүгнэгдсэн нь хүчин чадал, хүний нөөц, тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, анхан шатны маягт хөтлөлт, тоног төхөөрөмжийн ашиглалт, нэхэмжлэл жагсаалт, илэрсэн зөрчлийн хасагдал, хууль тогтоомжийн сургалт сурталчилгаа, даатгуулагчийн санал гомдол болон бусад холбогдох материалыг хамруулан баримтын шалгалт хийхэд ЭМДҮЗ-ийн 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 23 дугаар тогтоолын хэрэгжилт хангалтгүй, үзүүлж байгаа тусламж үйлчилгээ бодитой, чанартай эсэхэд үр дүнг тооцоогүй, ЭМТ нь ЭД-ын байцаагчтай хамтарч ЭМД-ын ач холбогдлыг сурталчлах, мэдээлэх ажлыг зохион байгуулаагүй, иргэдээс ирсэн саналыг дүгнэсэн боловч үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаагүй, хяналтаар илэрсэн зөрчлийг бууруулах ажил зохион байгуулаагүй, нэхэмжлэхийг хугацаандаа ирүүлээгүй тул 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр зөрчил арилгуулах тухай улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг "Даатгалын гэрээ дүгнэх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.2 дах "Даатгалын гэрээ дүгнэсэн үнэлгээний нийлбэр нь 71-80 оноогоор үнэлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад алдаа дутагдал, зөрчлөө арилгах талаар хугацаатай албан шаардлага хүргүүлж даатгалын гэрээг хэвээр үргэлжлүүлж, мөн шинэчлэн байгуулж болно. Албан шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд даатгалын гэрээг түдгэлзүүлэх хүртэл арга хэмжээ авна" гэсэн заалтыг дагуу албан шаардлага хүргүүлсэн байна.

ЭМДЕГ-ын даргын А/03 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын дагуу бүрдүүлэх материалыг хүлээн авч дүгнэсэн.

Сумын 18 ЭМТ-ийн гэрээний дүгнэлтийн дундаж үнэлгээ аймгийн хэмжээнд 91 хувь, 28 эмийн сангийн дүгнэлтийн дундаж үнэлгээ 90.0 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн байна.

ЭМДЕГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/175 дугаар тушаалд заасны дагуу 35 эмийн сангийн гэрээг дүгнэхээр байсан ч гэрээ байгуулаагүй, тусгай зөвшөөрөл дууссан, татан буугдсан, эрхлэгч нь Улаанбаатарт эмнэлэгт хэвтсэн тул гэрээгээ заасан хугацаанд дүгнүүлээгүй зэрэг нийт 7 эмийн сангийн гэрээг дүгнээгүй, 28 эмийн сангийн гэрээг дүгнэхэд 81-ээс дээш оноогоор үнэлэгдсэн 26, "Даатгалын гэрээ дүгнэх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх "Даатгалын гэрээ дүгнэсэн үнэлгээний нийлбэр нь 81-100 оноогоор үнэлэгдсэн эрүүл мэндийн байгууллагатай даатгалын гэрээг хэвээр үргэлжлүүлж, мөн шинэчлэн байгуулж болно", 3.1.2 дах "Даатгалын гэрээ дүгнэсэн үнэлгээний нийлбэр нь 71-80 оноогоор үнэлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад алдаа дутагдал, зөрчлөө арилгах талаар хугацаатай албан шаардлага хүргүүлж даатгалын гэрээг хэвээр үргэлжлүүлж, мөн шинэчлэн байгуулж болно" гэсэн заалтыг дагуу "Даатгалын гэрээ дүгнэх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.2 дах "Даатгалын гэрээ дүгнэсэн үнэлгээний нийлбэр нь 71-80 оноогоор үнэлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад алдаа дутагдал, зөрчлөө арилгах талаар хугацаатай албан шаардлага хүргүүлж даатгалын гэрээг хэвээр үргэлжлүүлж, мөн шинэчлэн байгуулж болно. Албан шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд даатгалын гэрээг түдгэлзүүлэх хүртэл арга хэмжээ авна" гэсэн заалтын дагуу 73 оноогоор үнэлэгдсэн "Элгэн Бугат" эмийн санд тавигдах нийтлэг шаардлага MNS5260:2015 стандартын 1, 2, 6, 7, 11, 13, 14, 20 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, ажилчдынхаа НДШ-ийг төлөөгүй, Эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчлах, мэдээлэх, ЭМД-д хамруулах үйл ажиллагааг ЭМБ-тай хамтран зохион байгуулаагүй, Эмийн жагсаалтад байх зайлшгүй эмийн хангамж 90 хувиас дээш байх, ЭМДС-гаас санхүүжих санхүүгийн нэхэмжлэхийг сар бүрийн сүүл, сарын эхний 5-ны өдрийн дотор цахимаар болон цаасаар ирүүлж хэвшээгүй тул 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөр албан шаардлага хүргүүлж тус эмийн сан нь тухайн зөрчлүүдийг заасан хугацаанд биелэлтийг хангаж ирүүлсэн, 68 оноогоор үнэлэгдсэн Тэшиг сумын "Эгийн хишиг" эмийн сан нь ажилчдынхаа НДШ-ийг эмийн сангийн нэр дээрээ төлөөгүй, эрхлэгч нь багийн Засаг дарга хийдэг тул НДШ-ээ сумын ЗДТГ-аар төлүүлдэг тул "Даатгалын гэрээ дүгнэх журам"-ын 3.1.3 дахь "Даатгалын гэрээ дүгнэсэн үнэлгээний нийлбэр нь 60-70 оноогоор үнэлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын даатгалын гэрээг түдгэлзүүлж, албан шаардлага хүргүүлж, түүний биелэлтийг үндэслэн гэрээг үргэлжлүүлэх, шинэчлэн байгуулах эсэхийг шийдвэрлэнэ" гэж заасны дагуу нэрээ өөрчилж гэрээг шинэчлэн байгуулах хүсэлт гаргасан байна.

Гэрээг дүгнэхэд нийтлэг гарч байгаа зөрчил нь хүний нөөц дутагдалтай туслах ажилчид гэрээгээр ажилладаг тул НДШ төлдөггүй, Эмийн сангийн эрхлэгч нь мэргэжлийн эм зүйч биш эм найруулагч мэргэжилтэй, ЭМДС-гаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн хангамж 90 хувьд хүрэхгүй, даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэсэн боловч түүний мөрөөр хийсэн ажил байхгүй байна.

2022 онд ЭМДЕГ-аас аймгийн нэгдсэн эмнэлэг, "Баатарван" сувилал, "Сожэд" хувийн эмнэлэг, 16 сум, 1 тосгоны эрүүл мэндийн төв гэсэн нийт 21 байгууллагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээг байгуулж ажиллажээ.

2022 онд 18 ЭМТ-тэй "Өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төвөөс зарим эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах гэрээ", 33 эмийн сантай

"Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ"-г байгуулсан боловч гэрээг дүгнээгүй байна.

***Б.1.6. Төр, хувийн хэвшлийн байгууллагуудын үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зарим зардлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэж олгоогүй байна.***

Эрүүл мэндийн даатгалын салбарт үйлчилж байгаа хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор төр төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээг ЭМД-ын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалттай нэгтгэн ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолыг баталж, хэрэгжилтийг 2021 оны 3 дугаар сарын 01-нээс эхлэн хангаж ажиллаж эхэлсэн байна.

Аймгийн 16 сум, 1 тосгоны улсын эмнэлэг 3, хувийн хэвшлийн эмнэлэг 4, Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв 16, рашаан сувилал 2, шүдний эмнэлэг 2, хөнгөлөлттэй эмээр үйлчилдэг 3 эмийн сан 2021 онд гүйцэтгэлээр 17,852,222.6 мянган төгрөгийн тусламж үйлчилгээний зардал нэхэмжилснээс хяналтаар 1,649,967.6 мянган төгрөг хасагдаж 16,202,255.0 мянган төгрөг олгохоор тооцож, 12,829,027.1 мянган төгрөгийн санхүүжилт олгожээ.

2022 онд 21,381,544.9 мянган төгрөгийн тусламж үйлчилгээний зардал нэхэмжилснээс хяналтаар 870,816.8 мянган төгрөг хасагдаж 20,510,728.1 мянган төгрөг олгохоор тооцож өмнөх оны өглөгтэй хамт 23,900,847.6 мянган төгрөгийн санхүүжүүлжээ. /Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харах/

Тусламж үйлчилгээний зардлын нэхэмжлэлээс 2021 онд нийт нэхэмжилсэн дүнгийн 9.2 хувь буюу 1,649,967.6 мянган төгрөг, 2022 онд 4.1 хувь буюу 870,816.8 мянган төгрөг хасагдаж алдааны дүн өмнөх оноос 44.5 хувиар буурсан байна.

Бугат сумын ЭМТ-д 2022 оны 2 дугаар сард ковид-19 халдвараар өвчилж хэвтэн эмчлүүлсэн өвчтөний жагсаалтад хэвтэн эмчлүүлээгүй 5 даатгуулагчийн, Сэлэнгэ сумын ЭМТ-д 2021 оны 9 дүгээр сард ковид-19 халдвараар өвчилж хэвтэн эмчлүүлсэн өвчтөний жагсаалтад хэвтэн эмчлүүлээгүй 5 даатгуулагчийн мэдээллийг тус тус оруулж 9,800,000.0 төгрөгийн санхүүжилт авсан байна.

Энэ нь Эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд өмнөх сарын нэхэмжилсэн дүнгээс хасагдсан шалтгаанд дүн шинжилгээ хийж, тодорхой ажил зохион байгуулж, цахим системийн талаар мэдлэгтээ анхаарч, мэдээллээ хугацаанд нь бүрэн оруулснаар, нөгөө талаас программын гацалт багасаж, программ хөгжүүлэлт хийгдсэн зэрэг нь тодорхой үр дүн гарахад нөлөөлсөн байна.

*График 2*




*Эх сурвалж: ЭМДХ-н тайлан мэдээ*

Хасагдсан санхүүжилтийн нийтлэг шалтгаан дараах байдлаас үүссэн. Үүнд:

Улсын эмнэлэг, сумын болон өрхийн эрүүл мэндийн төв

- Хяналтын үзлэг, оношны хамааралтай бүлэг зөрсөн, бусад тусламж, үйлчилгээтэй давхардсан,
- Эрүүл мэндийн даатгал төлөөгүй иргэнд тусламж үзүүлсэн,
- Нэг оношоор, 1 өдөр, 2 ба түүнээс дээш өөр оношны хамааралтай бүлгээр нэхэмжилсэн,
- Тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаад дараагийн шатлалын эмнэлэгт шилжин эмчлүүлсэн иргэнийг хэвтэн эмчлүүлсэн гэж төлбөрийг давхардуулан нэхэмжилсэн,
- 5 хүртэлх хоног хэвтэн эмчлүүлсэн иргэний төлбөрийг нэхэмжилсэн,
- Программ хангамжийн хөгжүүлэлт муу, гацдаг, программын талаар сургалт мэдээлэл, эмч нарын программ ашиглах мэдлэг дутуу,
- Түүвэрт хамрагдсан өвчний карт ирүүлээгүй, ирүүлсэн өвчний картыг бүрэн гүйцэд хөтлөөгүй, онош тодруулах оношилгоо шинжилгээ хийгдээгүй,
- Гэрээнд заагдаагүй оношоор нэхэмжилсэн,
- Боловсон хүчний нөөц бололцоо дутмаг байдгаас алсын дуудлагад явсан эмч тухайн өдрөө тусламж үйлчилгээний мэдээллээ программд оруулж амжаагүйгээс тухайн үйлчилгээний төлбөрөө нэхэмжилж чаддаггүй зэрэгтэй холбоотой байна.

ЭМТ-ийн эмийн нөөц үлдэгдлийг тулгах явцад ЭМЯ-аас орон нутгийн ЭМГ-аар дамжин эмнэлэг, ЭМТ-үүдэд ковид-19 өвчлөлд зориулж нийлүүлэгдсэн эм эмнэлгийн хэрэгслээс хугацаа дууссан эмийг устгахаар төлөвлөж байна.

Тухайлбал Нэгдсэн эмнэлэгт 2021 онд 831,517.2 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, 2022 онд 13,255.0 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгдсэнээс зарцуулагдаагүй үлдсэн, хугацаа дууссан актлахаар төлөвлөж буй үлдэгдэл 231,896.2 мянган төгрөгийн эм, 87,836.3 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл, Хангал сумын ЭМТ 523.6 мянган төгрөгийн эм, Хутаг-Өндөр сумын ЭМТ 65,166.2 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл актлахаар төлөвлөсөн байна.

Эндээс үзэхэд эмийн худалдан авалт, нийлүүлэлт зохистой тооцогдоогүй байна.

Эмийн сангуудын хувьд:

- Суманд дадлага туршлага бүхий их эмч хомс, ихэнхдээ шинэ төгсөгч ирдэг ч жил ажиллаад шилждэг, хөнгөлөлттэй эмийн жор бичихдээ эмийг олон улсын нэршлээр бичээгүй,
- Эмийн сангийн жор баригч эмчийн бичсэн хөнгөлөлттэй жороор эм олгохдоо үйлчлүүлэгчийн ЭМД төлсөн эсэхийг шалгалгүй олгодог,
- Иргэн хөнгөлөлттэй эм авах үедээ ЭМД-аа төлсөн шивэлт нь удаж орсноос ЭМБ санхүүжилтээ хасуулах нэг шалтгаан болдог байна.

Нөгөө талаас эмийн сангийн жор баригч хөнгөлөлтэй эмээр үйлчлэхдээ журмын дагуу жорыг хянаж, бичигдсэн өвчний оношны хувьд тухайн эмийн олон улсын нэршил, бичигдсэн эмийн тоо ширхэг, тун зөв эсэх, үйлчилгээ авах иргэн ЭМД төлсөн эсэх зэргийг хянаж алдаатай, эсвэл зөрүүтэй үед засуулж ажилласнаар зардлаа бүрэн авах боломжтой байна.

Тухайлбал 2021 онд" Мөнхийн Агар" ХХК ЭЭС, "Цомбон Гранд Булган" ХХК ЭЭС, "Сансар фарм" ХХК ЭЭС, "Эгийн хишиг" ХХК ЭЭС, 2022 онд "Орхон мандал" ХХК, "Бэрххангай" ХХК, "Цомбон Гранд Булган" ХХК, "Содонцэцэг" ХХК, "Мөнхийн

Агар" ХХК, "Хульж-Очир" ХХК, "Шива-Од" ХХК, "Эгийн хишиг" ХХК, "Ашид хас" ХХК-иуд нэхэмжилсэн санхүүжилтээ тус тус бүрэн авч ажилласан байна.

Эмийн сангийн 2021, 2022 оны тусламж, үйлчилгээний дэлгэрэнгүйг /Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас харах/

*График 3*




*Эх сурвалж: ЭМДХ-н тайлан мэдээ*

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар Эрүүл мэндийн төвүүдийн 2021 оны ковид цар тахалтай холбогдуулан олгосон тэтгэмж, урамшууллыг түүвэрлэн шалгахад Дашинчилэн сумын ЭМТ 17920950, Гурванбулаг сумын ЭМТ 13398648, Хутаг-Өндөр сумын ЭМТ 4750000 төгрөгийг тус тус хүчингүй болсон хуулийн заалтыг үндэслэн, НДШ-ийг суутган тооцоогүй, тэтгэмж давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", НББ-ийн тухай хуулийн 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13 дугаар зүйлийн 6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", ЭМС-ын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496, 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/585 тоот тушаалын заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоож төлбөрийг төсөвт төвлөрүүлэн ажилласан байна.

Сэлэнгэ сумын ЭМТ нь цалингийн зардлаас байгууллагын даргын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн Б/30 тоот "Урамшуулал олгох тухай" тушаал гаргасан нь ЭМС-ын болон аймгийн ЭМГ-ын даргын тушаал, шийдвэргүйгээр, ЭМС-ын 2022 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 1а/3543 тоот "Чиглэл хүргүүлэх тухай" албан бичгийг албан даалгавар гэж өөрчлөн, үндэслэлгүйгээр нийт 79200.0 мянган төгрөгийн тэтгэмж урамшуулал олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон үүнээс 21600.0 мянган төгрөгийг бардуулсан, Эрүүл мэндийн сайдын болон аймгийн ЭМГ-ын даргын тушаал шийдвэргүй, 2021 оны 11, 12 саруудад ковидын голомтод ажиллаагүй, шинээр 2022 оны 01 сард ажилд орсон 2 ажилтанд, мөн байгууллагын дарга тушаалын хавсралтад өөрийн нэрийг оруулан баталсан, мөн 2021 онд ЭМС-ын тушаалыг үндэслэж тэтгэмж урамшуулал, ковидын илүү цагийн нэмэгдэл зэргийг авсан бөгөөд давхардуулан 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Б/10 тоот "Урамшуулал олгох тухай" тушаалын 1 ба 2 дугаар хавсралтаар нийт ажилчдад 27500.0 мянган төгрөгийн тэтгэмж урамшуулал олгосон нь зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

***Б.2.1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд тусламж үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэхээр заасан боловч зарим иргэдийг бүрэн хамруулаагүй, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар үр дүнтэй ажил зохион байгуулаагүй байна.***

ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/10, 2022 оны А/13 тоот тушаалаар аймгийн ЭМД-д хамралтын төлөвлөгөөг баталжээ. Хамрагдалтыг сүүлийн гурван жилээр графикаар харуулбал: /Дэлгэрэнгүйг хавсралт 4-өөс харах/

*Хүснэгт 2. ЭМДХ-ийн 2021, 2022 оны хамрагдалт*

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2020 он** | Төлөвлөгөө | 2,900 | 8,600 | 1,100 | 12,600 |
| | Хамрагдалт | 1,447 | 3,747 | 831 | 6,025 |
| **2021 он** | Төлөвлөгөө | 2,900 | 8,600 | 1,100 | 12,600 |
| | Хамрагдалт | 815 | 3,040 | 456 | 4,311 |
| **2022 он** | Төлөвлөгөө | 2,610 | 6,900 | 1,100 | 10,610 |
| | Хамрагдалт | 1,100 | 2,919 | 269 | 4,288 |
| **Төлөвлөгөө /сууръ он-2020/** | Дүн | (290.0) | (1,700.0) | - | (1,990.0) |
| | Хувь | (10.0) | (19.8) | - | (15.8) |
| **Гүйцэтгэл /сууръ он-2020/** | Дүн | (632.0) | (707.0) | (375.0) | (1,714.0) |
| | Хувь | (43.7) | (18.9) | (45.1) | (28.4) |
| **Гүйцэтгэл /сууръ он-2021/** | Дүн | 285.0 | (121.0) | (187.0) | (23.0) |
| | Хувь | 35.0 | (4.0) | (41.0) | (0.5) |

*Эх сурвалж: ЭМДЕГ-ийн 2020, 2021, 2022 оны гүйцэтгэл*

Аймгийн НДХ-ээс 2021 оны 02 дугаар сарын 17-ны 1-1/81 тоот албан бичгээр ЭМД төлөөгүй иргэдийг хамруулах, www.health.gov.mn сайжруулалтад анхаарах сургалт сурталчилгаа явуулах ажлыг зохион байгуулах хамтран ажиллах, ЭМДЕГ НДЕГ-ын 2020 оны 01 дүгээр сарын 14-ний 01/70, 02/Ч01 албан бичгийг баримтлан ЭМД-д хамрагдаагүй иргэдэд аймгийн ЭМДХ-ээс "Хүрч үйлчилье" арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын ажлын хэсэгтэй хамтран сумдад ажиллаж ЭМД төлснөөр ямар ямар үйлчилгээнд хамрагдах боломжтой талаар сургалт, сурталчилгааг 2022 онд явуулжээ.

ЭМБ-ын гэрээний биелэлтийн шалгуурт ЭМД-ийн талаар сурталчлах, мэдээлэл өгсөн талаар тусгасан ч ямар баримт нотолгоонд үндэслэж үнэлсэн нь тодорхой бус байна.

Дээрх хүснэгтээс харахад 2021 онд хамруулах иргэдийн тоог өмнөх оноос өөрчлөөгүй, 2022 онд 1990 иргэнээр буюу өмнөх оноос 15.8 хувиар бууруулж баталжээ. Гүйцэтгэлээр 2021 онд 34.2, 2022 онд 40.4 хувьтай ч хамрагдсан иргэдийг өмнөх онуудтай харьцуулахад 2021 онд 28.4, 2022 онд 0.5 хувийн бууралттай нь ЭМД-д хамруулах арга хэмжээ үр дүн муутайг илэрхийлж байна. Мөн аймгийн НДХ-ээс ирүүлсэн нийт хамрагдсан иргэдийн тоо ЭМДЕГ-ын гүйцэтгэлээр ирүүлсэн тоон мэдээлэл зөрүүтэй нь нийт тайлан мэдээ, гүйцэтгэл үнэн зөв, бодиттой илэрхийлэгдээгүй байх эрсдэлтэй байна.

***Б.2.2.Хуульд заасны иргэдийг мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагуудын уялдаа холбоог хангасан цахим системийн хөгжүүлэлт хангалтгүй байна.***

Аудитаар эрүүл мэндийн байгууллага, ЭМДХ, яамны хоорондын ажил төрлийн болон цахим харилцааг судалж үзэхэд

- Нийтээр хэрэглэдэг https://ebarimt.mn/ хаягаар төлбөр төлөхөд эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт программд шуурхай татагддаг сайн талтай байхад

эрүүл даатгалын мэндийн шимтгэлээ төлөөгүй иргэн яаралтай тусламж үйлчилгээ авах тохиолдолд банкны харилцах дансаар төлбөр төлөхөд программд шимтгэл төлөлтөөр бүртгэгдэх хугацаа НДХ-ийн мэргэжилтний орлого шивсэн хугацаанаас хамаарч удаашралтай байдаг тул тухайн иргэнд үзүүлсэн тусламж үйлчилгээний зардал хасагддаг,

- Тусламж үйлчилгээний программ хангамж ашиглалтын хувьд дутагдалтай, программын талаар сургалт хийдэггүй, хөгжүүлэлтийг тухай бүр хийж, хийсэн өөрчлөлтийн талаар хэрхэн яаж ашиглах талаар мэдээлэл өгдөггүй *Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн* 16.1.8 "эрүүл мэндийн даатгалын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;" заалт хангалтгүй хэрэгжиж байгааг харуулж байна.

***Б.2.3.Эрүүл мэндийн байгууллага болон иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд үр дүнтэй шийдвэрлээгүй байна.***

Аймгийн ЭМДХ-ийн баримтаар 2021 онд 1 өргөдөл, гомдол ирүүлснийг шийдвэрлэсэн бол 2022 онд өргөдөл, гомдол ирээгүй байна.

Аудитын талбарын үе шатанд нэхэмжлэхтэй холбоотой гомдол хүсэлт хүргүүлдэг, хэрхэн шийдвэрлэдэг талаар тодруулахад сумдын ЭМТ зарим тохиолдолд албан тоотоор болон албан бус, Нэгдсэн эмнэлэг албан тоотоор хүсэлт хүргүүлдэг ч зарим хүсэлтэд хариу ирүүлдэггүй, ялангуяа ЭМДХ-т эмчгүй болсноос хойш хасалт хийсэн шалтгаан тайлбар ирээгүй тухай тайлбар өгсөн.

Аймгийн ЭМДХ ЭМБ-аас ирүүлсэн нэхэмжлэлтэй холбоотой хүсэлтийг тусад нь өргөдлийн бүртгэлд тусгадаггүй бөгөөд ЭМДЕГ-т дамжуулан хүргэх үүргийг гүйцэтгэж байна.

Түүвэрлэн тулгалт хийхэд Нэгдсэн эмнэлгээс /Дэлгэрэнгүйг хавсралт 5-аас харах/ ирүүлсэн зарим хүсэлтийг хянаж хэрхэн шийдвэрлэсэн нь тодорхой бус байгаа нь ЭМДҮЗ-ийн 2021 оны 05 дугаар тогтоолын 5.1.12[1], 5.1.13[2], ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/98 дугаар тогтоолын 6.2[3]-т заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

***Б.3.1. ЭМДЕГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/60 дугаар тушаалаар "Эрүүл мэндийн байгууллага дээр очиж хийх хяналт, шалгалтын журам"-ыг баталж, ЭМДЕГ-ын даргын А/98 тоот тушаалын дагуу төлөвлөгөө удирдамж боловсруулж арга хэмжээний хэрэгжилтэд хууль тогтоомж, журамд заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг 2 эмнэлэг, 2 рашаан сувилалд хийхэд хэвийн үйл ажиллагаатай байна.***

ЭМДХ нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас бүтэн жилээр гаргаж ЭМДЕГ-ын даргын дэргэдэх зөвлөл, Дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний газраар үнэлүүлж 2021 онд 85.4 хувь буюу "В" үнэлгээтэй дүгнэгдэж, 2022 онд 86.6 хувь буюу "В" үнэлгээтэй дүгнэгдэж тус үнэлгээг аймгийн Засаг даргатай байгуулсан 2022 оны гэрээний дагуу Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж баталгаажуулсан байна.

---

*[1] ЭМБ нь нэхэмжлэлийн хяналтын үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол нэхэмжлэлийн хяналтын мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан гомдлоо ЭМДЕГ-ын Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын газарт ирүүлнэ.*

*[2] ЭМДЕГ-ын Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын газар нь ЭМБ-аас нэхэмжлэлийн үр дүнгийн талаар ирүүлсэн гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан хянан үзэж хариу тайлбарыг өгнө.*

*[3] НХХ, орон нутгийн ЭМДХ нь нэхэмжлэлийн хяналттай холбоотой ЭМБ-аас ирүүлсэн санал, гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан хяналт хийн хариу тайлбарыг албан бичгээр хүргүүлнэ*

Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/60 дугаар тушаалаар "Эрүүл мэндийн байгууллага дээр очиж хийх хяналт, шалгалтын журам"-ыг баталж, Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар Хяналт, шалгалт хийх ажлын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралт, хяналт хийх ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралт, шаардагдах төсвийг гуравдугаар хавсралтаар баталсан байна.

ЭМДҮЗ-ийн 05 дугаар тогтоол, ЭМДЕГ-ын даргын А/98 тоот тушаалын дагуу 2021 онд нэхэмжлэлийн хяналтыг 8 дугаар сараас эхлэн нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн 2 эмнэлэг, 2 рашаан сувилалд хийсэн. ЭМДЕГ-ын даргын А/98 тоот тушаалын зургаадугаар хавсралтын 3 хүснэгтээр хянасан тайлангаа сар бүр эмнэлгүүдэд хүргүүлж аймгийн нэгдсэн эмнэлэг, "Баатарван" рашаан сувилалд нэхэмжлэл хянасан тухай болон гарсан алдаа зөрчлийн дагуу зөвлөмжийг албан бичгээр өгсөн ба хувийн эмнэлгүүд ирж заавар зөвлөгөө авч ажиллажээ.

ЭМДЕГ-ын даргын баталсан Орон нутаг дахь өрхийн ЭМТ-ийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих удирдамжийн дагуу 2 өрхийн эрүүл мэндийн төвийн гэрээний хэрэгжилт болон ковид 19 халдварт өвчний улмаас гэрээр тусгаарлагдан эмчлэгдсэн тохиолдлын хяналт хэрхэн явагдаж байгаа талаар хяналт шалгалт хийн заавар зөвлөгөө өгч ажилласан байна.

Булган аймаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтэс 2 хүний бүрэлдэхүүнтэй эрүүл мэндийн байгууллагад газар дээрх хяналтыг 1 улсын эмнэлэг, 1 рашаан сувилал дээр 2022 оны 11 дүгээр сарын 16-наас 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрүүдэд хийж, газар дээр очиж эмнэлгийн байр, тасгуудын өрөө, шаардлагатай хүний нөөцийн диплом, лиценз, мэргэжлийн үнэмлэх, НДШ-ийн тайлан, тоног төхөөрөмжийн ашиглалт, сери дугаар, техник ашиглалтын паспорт, одоо хэвийн ажиллаж байгаа эсэхийг шалгаж газар дээр нь очиж хяналт шалгалт хийж үзэхэд хэвийн үйл ажиллагаатай ажиллажээ.

***Б.3.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлд зохих хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж тавиагүй байх.***

ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/98 тоот тушаалаар батлагдсан "нэхэмжлэлийн хяналт хийх журам"-ын хэрэгжилтийг баримтад тулгуурлан үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Цахим хяналтын шалгуур хангаагүй нэхэмжлэлийн төлбөрийн хасалтыг программ автоматаар хийж, хасалт хийсэн дүнтэй дүгнэлтийн тайланг орон нутгийн ЭМДХ-т 2022 оны 08 дугаар сараас хойш чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн эмч өөр аймаг, хотод шилжсэн ч оронд нь ажиллах хүнгүй байснаас гаргаж өгөөгүй,
- Цахим хяналт хийсэн тухай солилцох хуудас ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/98 тоот тушаалын тавдугаар хавсралт цахим хяналт хийсэн тухай солилцох хуудсыг ЭМДЕГ орон нутгийн ЭМДХ-т хүргүүлж ажилладаггүй,
- Нэхэмжлэлийн хяналт хийсэн тухай тайланг цахимаар гаргаж сар бүр албан ёсны цахим хаягаас тухайн Эрүүл мэндийн байгууллагад илгээдэггүй,
- Мэдээллийн технологийн хэлтэс нь Эрүүл мэндийн байгууллагуудын нэхэмжилсэн дүнгээс хасагдсан нэхэмжлэлээ цахим программаар дэлгэрэнгүй харах боломжийг бий болгоогүй,
- Эрүүл мэндийн байгууллагуудаас ирсэн санал, хүсэлтийг ирсэн бичгээр бүртгэлгүй, тухай бүр дээд газарт дотоод сүлжээгээр явуулж шийдвэрлүүлдэг,

- Орон нутгийн ЭМДХ нь хяналт хийсэн мэдээллийг архив, бичиг хэргийн стандартад заасны дагуу цахим хэлбэрээр архивын нэгж үүсгэж цахим архив үүсгэдэггүй байна.

***Б.3.3. Эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй нь тус ЭМДХ-ийн үйл ажиллагаа, хяналт хууль журмын дагуу явуулаагүй байх эрсдэлтэй байна.***

Аудитын хамрах хугацаанд тус ЭМДХ-т эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна. Энэ нь тус хэлтсийн үйл ажиллагаа, хяналт шалгалтыг үр дүнтэй хууль, журмын дагуу явуулаагүй байх эрсдэлтэй байна.

***Б.3.4. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлыг ЭМДЕГ-аас шийдвэрлэдэг байна.***

Аймаг дахь ЭМДХ нь дарга 1, чанар төлбөрийн хяналтын мэргэжилтэн 3 нийт 4 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаа, байгууллагын үйл ажиллагааны зардлыг ЭМДЕГ-аас шийдвэрлэдэг учир www.shilendans.gov.mn цахим системд мэдээлэл байршуулдаггүй, мөн төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэлгүй байна.

**ДҮГНЭЛТ:** Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ЭМБ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу хасалт хийсэн нэхэмжлэлд дахин хяналт явуулахад зарим тохиолдолд хасалтыг цуцалсан нь хяналтыг дутуу, алдаатай гүйцэтгэсэн,
- ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/98 тушаалаар гүйцэтгэлийн 5-15 хувьд түүврийн хяналтыг цахимаар хэрэгжүүлж 2021 онд 1,650.0 сая төгрөг, 2022 онд 870.8 сая төгрөгийн хасалт хийсэн,
- Гэрээнд тухайн ЭМБ-ийн хүчин чадлын хэмжээг тусгасан ч гүйцэтгэлийг буюу гэрээг дүгнэхэд тухайн үзүүлэлтийг харгалзан үзээгүй, тооцоолоогүй,
- Нэхэмжлэлийг хугацаанд нь ирүүлсэн эсэхийг гэрээ дүгнэх үзүүлэлт болдог ч ЭМБ-аас журамд заасны дагуу албан тоотоор нэхэмжлэхийг цаасаар болон цахимаар ирүүлснийг аймгийн ЭМДХ бүртгэл хөтөлдөггүй нь гэрээг бодитоор дүгнээгүй байх эрсдэлтэй,
- "Хүрч үйлчилье" арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын ажлын хэсэгтэй хамтран сумдад ажиллаж зарим иргэдийг ЭМД-д хамруулсан,
- 2021 онд хамруулах иргэдийн тоог өмнөх оноос өөрчлөөгүй, 2022 онд 1990 иргэнээр буюу өмнөх оноос 15.8 хувиар бууруулж баталсан бөгөөд гүйцэтгэлээр 2021 онд 34.2, 2022 онд 40.4 хувьтай ч хамрагдсан иргэдийг өмнөх онуудтай харьцуулахад 2021 онд 28.4, 2022 онд 0.5 хувийн бууралттай нь ЭМД-д хамруулах арга хэмжээ үр дүн муутай,
- Аймгийн НДХ-ээс ирүүлсэн нийт хамрагдсан иргэдийн тоо ЭМДЕГ-ын гүйцэтгэлээр ирүүлсэн тоон мэдээлэл зөрүүтэй,
- ЭМБ-ын гэрээний биелэлтийн шалгуурт ЭМД-ийн талаар сурталчлах, мэдээлэл өгсөн талаар тусгасан ч ямар баримт нотолгоонд үндэслэж үнэлсэн нь тодорхой бус,
- Аймгийн ЭМДХ-т 2021онд 1 өргөдөл ирсэн бөгөөд хариуг хүргүүлж ажилласан,

- Хасалт хийсэн нэхэмжлэлд ЭМБ-аас албан тоотоор хүсэлт ирүүлж аймгийн ЭМДХ-ээр дамжин ЭМДЕГ-т хүргүүлдэг ч зарим хүсэлтийн хариу хэрхэн яаж шийдвэрлэсэн талаарх баримт нотолгоо байхгүй,
- Аймгийн ЭМДХ-т эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.
- Эрүүл мэндийн байгууллагууд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн үйл ажиллагааны хууль, журамд заасан нөхцөл, шаардлагын чанд мөрдөж хариуцлагатай ажиллавал санхүүжилтээ бүрэн авах боломжтой,
- ЭМБ иргэдэд үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоонд шилжсэнээр тусламж үйлчилгээ хүссэн иргэний ЭМД-н шимтгэл төлөлтийг шалгаж, төлөгдөөгүй үед хэрхэн төлбөрөө төлөх зөвлөмж өгч үйлчилснээр ЭМД-д хамрагдалт нэмэгдэх хөшүүрэг болох давуу талтай,
- Сум, тосгоны ЭМТ нь алслагдсан багт, хүн бүл цөөтэй тэр бүр эмнэлгийн тусламж үйлчилгээг зорьж очиж авч чаддаггүй малчин өрхийн гишүүдийг тусламж үйлчилгээнд хамруулахаар гэрээнд тусган, биелэлтийг хангаж ажиллаж байгаа,
- Эрүүл мэндийн байгууллага орчин нөхцөл сайжирч, тоног төхөөрөмж, тохижилт, боловсон хүчний нийгмийн баталгааг хангах зэрэг тулгамдсан асуудлаа байгууллагынхаа хүрээнд шийдвэрлэх зэрэг сайн талууд байна.
- 5 хүртэлх хоногийн тусламж, үйлчилгээ авсан иргэн, тусламж, үйлчилгээг ахиулан авсан тухайлбал яаралтай тусламжийн үйлчилгээ авч улмаар сэхээн амьдруулах тасаг шилжсэн иргэний төлбөрийг нэхэмжлэх зохицуулалтгүйгээс эмнэлгийн байгууллага алдагдал хүлээх эрсдэлтэй,
- Санхүүжилтийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад биш байгууллагын ажиллагсдад тэтгэмжийг хавтгайруулан олгох зэргээ төсвийг үр ашиггүй, хяналт, тооцоололгүй үрэлгэн зарцуулах тал байгаа,
- Тусламж үйлчилгээг заасан журмын дагуу бүрэн шивж илгээгээгүйгээс санхүүжилтээ бүрэн авч чадахгүй байгаа нь тухайн Эрүүл мэндийн байгууллагын санхүү, хүний нөөц, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах нөөц боломжийг алдаж байгаа сул талтай,
- Эмч, эмнэлгийн ажилтнаар төгсөж буй залуучууд орон нутагт ажиллах орчин нөхцөл, цалин, хангамж муу байдгаас ЭМТ-д ажиллах боловсон хүчин хомс, батлагдсан орон тоогоор ажиллаж чадахгүй байгаа,
- ЭМДХ-ээс ирүүлсэн тоо мэдээ буруу илэрхийлэгдсэн /авлагыг өглөгөөр тусгасан/, хяналт хийсэн мэдээллийг архив, бичиг хэргийн стандартад заасны дагуу цахим хэлбэрээр архивын нэгж үүсгээгүй, эмх цэгцгүй, ажлын чанарын сайжруулах шаардлагатай,
- ЭМДЕГ, НДЕГ хамтран жил бүр ЭМДС-д төвлөрөх орлогын төлөвлөгөөг баталж байгаа боловч төлөвлөгөөг бодитой, үндэслэлтэй төлөвлөж батлаагүйгээс 2022 оны ЭМДС-ийн орлогын төлөвлөгөө 41.9 хувиар биелээгүй байна.
- ЭМДЕГ даргын 2022 оны А/10 дугаар тушаалыг мөрдөж ажиллаагүйгээс бүтэц орон тооны дутагдалтай ажилласнаар ЭМБ-ууд зөрчил дутагдлаа арилгаж санхүүжилтээ бүрэн авч чадахгүй байгаа,
- ЭМДЕГ, аймгийн Эрүүл мэндийн байгууллагуудын даатгалын гэрээг 2022 онд дүгнээгүй,
- ЭМДХ нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас бүтэн жилээр гаргаж ЭМДЕГ-ын даргын дэргэдэх зөвлөл, Дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний газраар дүгнэхдээ тухайн албан хаагчийн иргэдэд үзүүлсэн үйлчилгээний чанар, хүртээмжийг харгалзан дүгнэдэг байна.

**ЗӨВЛӨМЖ:** АУДИТЫН ДҮН, ДҮГНЭЛТ НОТЛОХ ЗҮЙЛСТ ҮНДЭСЛЭН ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ ӨГЧ БАЙНА.

**Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга Б.Ариунболд танаа:**

1. Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн А/10 тушаалыг мөрдөж батлагдсан орон тоог бүрэн ажиллуулах.
2. Аймгийн ЭМДХ, НДХ-ийн хамтын ажиллагааг сайжруулж, ЭМД-д хамрагдаагүй иргэдийн хамруулах арга хэмжээг оновчтой зохион байгуулах.
3. Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/60 дугаар тушаалаар баталсан "Эрүүл мэндийн байгууллага дээр очиж хийх хяналт, шалгалтын журам"-ыг мөрдөж хяналт шалгалтыг сайжруулах.

**Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад:**

1. Сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг сайжруулж ЭМДС-гаас хүссэн санхүүжилтийн анхан шатны баримтыг хянан баталгаажуулах Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга журмыг мөрдөх, Эмийн сангуудын эмийн хангамжийг сайжруулж даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авч түүний мөрөөр ажил зохион байгуулах.

**ГНАГ-т хүргүүлэх санал:**

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй, бодитой төлөвлөх.
2. Цахим мэдээллийн систем нь хөгжүүлэлт муутай, гацдаг, программын шинэчлэлттэй холбоотой мэдээ мэдээлэл, сургалт тухай бүр хийж хэвшүүлэх мөн программын төлбөр төлж байгаа ЭМБ-т программын сургалт, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах.
3. Нэхэмжлэлийн хяналттай холбоотой ЭМБ-аас ирүүлсэн санал, гомдлыг батлагдсан журмын дагуу бүрэн шийдвэрлэх зөвлөмжийг ЭМДЕГ-т хүргүүлэх

*Хавсралт 1*

## ЭМДХ, ЭМДЕГ-ийн санхүүгийн тайлангийн дүнгийн харьцуулалт

| Он | Нэр | ЭМДХ-ийн тайлангаар | | | ЭМДЕГ-ийн тоон мэдээгээр | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нэхэмжилсэн | Хассан | Олгохоор тооцсон | Нэхэмжилсэн | Олгохоор тооцсон | Нэхэмжилсэн | Олгохоор тооцсон |
| 2021 он | Хульж | 5,250.00 | 750.00 | 4,500.00 | 1,955.00 | - | 3,295.00 | 4,500.00 |
| | Баатарван | 523,116.34 | 51,316.34 | 471,800.00 | 518,616.34 | 467,300.00 | 4,500.00 | 4,500.00 |
| | Нийт | **528,366.34** | **52,066.34** | **476,300.00** | **520,571.34** | **467,300.00** | 7,795.00 | 9,000.00 |
| 2022 он | Хульж | - | - | - | 9,000.00 | 8,250.00 | (9,000.00) | (8,250.00) |
| | Баатарван | 670,395.50 | 54,825.00 | 615,570.50 | 678,623.00 | 615,570.50 | (8,227.50) | - |
| | Нийт | **670,395.50** | **54,825.00** | **615,570.50** | **687,623.00** | **623,820.50** | (17,227.50) | (8,250.00) |

*Хавсралт 2*

## АЙМГИЙН ЭМДХ-ИЙН 2021, 2022 ОНЫ САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ /ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААР/

*/сая төгрөгөөр/*

| Утга | 2021 он | | | | | | | 2022 он | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Нэхэмжилсэн | | Хасагдсан | | Олгохоор тооцсон | | Нэхэмжилсэн дүнд эзлэх хасагдлын | Нэхэмжилсэн | | Хасагдсан | | Тооцсон | | Нэхэмжилсэн дүнд эзлэх хасагдлын |
| | Хүн | мөнгөн дүн | Хүн | мөнгөн дүн | Хүн | мөнгөн дүн | | Тоо | Мөнгөн дүн | Тоо | Мөнгөн дүн | Тоо | Мөнгөн дүн | |
| Улсын эмнэлгийн дүн | 78,841 | 5,136.0 | 7,748 | 467.6 | 71,093 | 4,668.3 | **2.6%** | 104,498 | 7,877.3 | 6,661 | 532.4 | 97,837 | 7,344.9 | **2.5%** |
| Хувийн эмнэлэг нийт дүн | 1,103 | 461.5 | 17 | 11.9 | 1,086 | 449.6 | **0.1%** | 343 | 168.9 | 34 | 13.3 | 309 | 155.6 | **0.1%** |
| Сувилал нийт дүн | 2,100 | 528.4 | 103 | 52.1 | 1,997 | 476.3 | **0.3%** | 2,909 | 670.4 | 179 | 54.8 | 2,730 | 615.6 | **0.3%** |
| ӨЭМТ ҮТ нийт дүн | 428 | 11.4 | 109 | 1.5 | 319 | 9.9 | **0.0%** | 463 | 13.5 | 114 | 2.6 | 349 | 10.9 | **0.0%** |
| СЭМТ ҮТ нийт дүн | 10,509 | 299.6 | 600 | 20.2 | 9,909 | 279.4 | **0.1%** | 13,216 | 443.0 | 1,105 | 48.3 | 12,111 | 394.6 | **0.2%** |
| Урьдчилан сэргийлэх нийт дүн | 3,967 | 141.5 | 40 | 0.4 | 3,927 | 141.1 | **0.0%** | 1,330 | 4.7 | | - | 1,330 | 4.7 | **0.0%** |
| Эрт илрүүлэг нийт дүн | - | - | - | - | - | - | **0.0%** | 1,667 | 194.2 | 279 | 41.0 | 1,388 | 153.1 | **0.2%** |
| Энгийн эм нийт дүн | 45,829 | 1,410.9 | 32 | 5.1 | 45,797 | 1,405.8 | **0.0%** | 70,261 | 1,681.1 | 152 | 13.8 | 70,109 | 1,667.4 | **0.1%** |
| В вирусын эм нийт дүн | 694 | 35.9 | | - | 694 | 35.9 | **0.0%** | 663 | 35.8 | 2 | 0.1 | 661 | 35.6 | **0.0%** |
| С вирусын эм нийт дүн | 19 | 5.7 | 1 | 0.2 | 18 | 5.5 | **0.0%** | - | - | - | - | - | - | **0.0%** |
| Ковид вакцин нийт дүн | 92,898 | 464.5 | | - | 92,898 | 464.5 | **0.0%** | 9,527 | 47.8 | | - | 9,527 | 47.8 | **0.0%** |
| Ковид өрх нийт дүн | 5,413 | 866.1 | 1,864 | 304.0 | 3,549 | 562.1 | **1.7%** | 1,474 | 235.8 | 123 | 19.7 | 1,351 | 216.2 | **0.1%** |
| Ковид хэвтэн нийт дүн | 6,959 | 8,335.4 | 344 | 778.4 | 6,615 | 7,557.0 | **4.4%** | 983 | 1,141.5 | 134 | 141.6 | 849 | 999.9 | **0.7%** |
| Ковид ПГУ-50000 нийт дүн | - | - | - | - | - | - | **0.0%** | 1,494 | 74.7 | 62 | 3.1 | 1,432 | 71.6 | **0.0%** |
| Нэгдсэн эмнэлэг Тандалт | 193 | 1.0 | 148 | - | 45 | 1.0 | **0.0%** | | - | | - | | - | **0.0%** |
| Ковид ПСР-5000 нийт дүн | 3,066 | 153.3 | 169 | 8.5 | 2,897 | 144.9 | **0.0%** | | - | | - | | - | **0.0%** |
| ӨЭМТ анхан шатны санхүүжилт | - | - | - | - | - | - | **0.0%** | 12,581 | 570.4 | | - | 12,581 | 570.4 | **0.0%** |
| СЭМТ анхан шатны санхүүжилт | - | - | - | - | - | - | **0.0%** | 48,935 | 6,565.4 | | - | 48,935 | 6,565.4 | **0.0%** |
| Анхан шатны тусламж үйлчилгээ 91 | - | - | - | - | - | - | **0.0%** | 1,548 | 1,657.2 | | - | 1,548 | 1,657.2 | **0.0%** |
| Элэг бүтэн дүн | 311 | 1.1 | | 0.0 | 311 | 1.1 | **0.0%** | | - | | - | | - | **0.0%** |
| **Нийт дүн** | **252,330** | **17,852.2** | **11,175** | **1,650.0** | **241,155** | **16,202.3** | **9.2%** | **271,892** | **21,381.5** | **8,845** | **870.8** | **263,047** | **20,510.7** | **4.1%** |

*Хавсралт 3*

# АЙМГИЙН ЭМДХ-ИЙН 2021, 2022 ОНЫ САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ /ЭМИЙН САНГУУД/

*/сая төгрөгөөр/*

| № | Эрүүл мэндийн байгууллагын нэр | Нэхэмжилсэн | | Хасагдсан | | Олгохоор тооцсон | | Нэхэмжлэлд эзлэх хасагдлын |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүн тоо | мөнгөн дүн | Хүн тоо | мөнгөн дүн | Хүн тоо | мөнгөн дүн | |
| | **2021 он** | | | | | | | |
| 1 | Мөнхийн Агар ХХК ЭЭС | 593 | 16.4 | | - | 593 | 16.4 | 0.00% |
| 2 | Цомбон Гранд Булган ХХК ЭЭС | 303 | 8.6 | | - | 303 | 8.6 | 0.00% |
| 3 | Сансар фарм ХХК ЭЭС | 91 | 1.9 | | - | 91 | 1.9 | 0.00% |
| 4 | Эгийн хишиг ХХК ЭЭС | 420 | 17.1 | | - | 420 | 17.1 | 0.00% |
| 5 | Бүрэг морьт ХХК ЭЭС | 701 | 20 | 1 | 0 | 700 | 20 | 0.05% |
| 6 | Шинэ тун ХХК ЭЭС | 411 | 16.5 | | 0 | 411 | 16.5 | 0.10% |
| 7 | Бодьбүрэг ХХК ЭЭС | 874 | 21 | | 0 | 874 | 21 | 0.16% |
| 8 | Саранмичид ХХК ЭЭС | 1,149 | 35.3 | 1 | 0 | 1,148 | 35.3 | 0.16% |
| 9 | Эрдэнэтун ХХК ЭЭС | 1,864 | 56.5 | | 0 | 1,864 | 56.4 | 0.31% |
| 10 | Цэгээн тун ХХК ЭЭС | 1,147 | 36.9 | 2 | 0 | 1,145 | 36.9 | 0.32% |
| 11 | Собц ХХК ЭЭС | 1,964 | 47.6 | 2 | 0.1 | 1,962 | 47.5 | 0.38% |
| 12 | Хангалбамбай ХХК ЭЭС | 364 | 11 | | 0.1 | 364 | 11 | 0.40% |
| 13 | Буман жор ХХК ЭЭС | 754 | 45.5 | 1 | 0.1 | 753 | 45.4 | 0.41% |
| 14 | Уянга хулст ХХК ЭЭС | 1,955 | 64.3 | 2 | 0.1 | 1,953 | 64.2 | 0.41% |
| 15 | Орхонмандал ХХК ЭЭС | 2,317 | 70.4 | 3 | 0.1 | 2,314 | 70.3 | 0.49% |
| 16 | Элгэн бугат ХХК ЭЭС | 1,244 | 41.7 | | 0.1 | 1,244 | 41.7 | 0.49% |
| 17 | СХМ Таван-од ХХК ЭЭС | 7,096 | 228.6 | 3 | 0.1 | 7,093 | 228.6 | 0.49% |
| 18 | Хутагтэмүүлэл ХХК ЭЭС | 3,170 | 101.9 | 1 | 0.1 | 3,169 | 101.9 | 0.56% |
| 19 | Моносцэцэг ХХК ЭЭС | 1,503 | 33 | 2 | 0.1 | 1,501 | 32.9 | 0.60% |
| 20 | Бэрххангай ХХК ЭЭС | 457 | 19.2 | | 0.1 | 457 | 19.1 | 0.62% |
| 21 | Эгийн далай ХХК ЭЭС | 1,713 | 68.1 | | 0.1 | 1,713 | 68 | 0.73% |
| 22 | Зууннаст ХХК ЭЭС | 1,074 | 32.6 | 3 | 0.1 | 1,071 | 32.5 | 0.89% |
| 23 | Баяннуур-эм ХХК ЭЭС | 1,267 | 29.8 | 4 | 0.1 | 1,263 | 29.6 | 1.05% |
| 24 | Тэмээн хөх ХХК ЭЭС | 1,541 | 46.8 | 3 | 0.2 | 1,538 | 46.6 | 1.22% |
| 25 | Сэлэнгэ-Анар ХХК ЭЭС | 3,339 | 94.2 | | 0.2 | 3,339 | 94 | 1.43% |
| 26 | Шилмэлцэцэг ХХК ЭЭС | 1,157 | 29.9 | | 0.3 | 1,157 | 29.6 | 2.21% |
| 27 | Монос булган ХХК ЭЭС | 1,796 | 44.6 | | 0.4 | 1,796 | 44.3 | 2.73% |
| 28 | Мөнгөн тун ХХК ЭЭС | 1,211 | 49.1 | | 0.4 | 1,211 | 48.7 | 3.05% |
| 29 | Булган Эм Хангамж ХХК ЭЭС | 4,059 | 110.3 | 3 | 0.6 | 4,056 | 109.7 | 4.03% |
| 30 | Хульж Очир ХХК ЭЭС | 295 | 12.1 | 1 | 1.8 | 294 | 10.3 | 13.05 % |
| | **Эмийн сангийн дүн** | **41,287** | **1,410.90** | **32** | **5.1** | **45,797** | **1,405.80** | **0.36%** |
| | **2022 он** | | | | | | | |
| 1 | Орхон мандал ХХК | 775 | 21.9 | | - | 775 | 21.9 | 0.00% |
| 2 | Бэрххангай ХХК | 7 | 0.3 | | - | 7 | 0.3 | 0.00% |
| 3 | Цомбон Гранд Булган ХХК | 313 | 9.9 | | - | 313 | 9.9 | 0.00% |
| 4 | Содонцэцэг ХХК | 551 | 28.5 | | - | 551 | 28.5 | 0.00% |
| 5 | Мөнхийн Агар ХХК | 390 | 11.3 | | - | 390 | 11.3 | 0.00% |
| 6 | Хульж-Очир ХХК | 375 | 15.2 | | - | 375 | 15.2 | 0.00% |
| 7 | Шива-Од ХХК | 11423 | 35.1 | | - | 11423 | 35.1 | 0.00% |
| 8 | Эгийн хишиг ХХК | 37 | 1.6 | | - | 37 | 1.6 | 0.00% |
| 9 | Ашид хас ХХК | 220 | 6.6 | | - | 220 | 6.6 | 0.00% |
| 10 | Эрдэнэ тун ХХК | 1834 | 57.2 | 1 | 0.1 | 1833 | 57.1 | 0.33% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | Булган Эм Хангамж ХХК | 3761 | 100 | | 0.1 | 3761 | 99.9 | 0.37% |
| 12 | Монос Булган ХХК | 2923 | 77.7 | | 0.1 | 2923 | 77.6 | 0.37% |
| 13 | Цэгээн тун ХХК | 1185 | 34 | 1 | 0.1 | 1184 | 34 | 0.45% |
| 14 | Бүрэг морьт ХХК | 1344 | 43.1 | 2 | 0.1 | 1342 | 43 | 0.64% |
| 15 | Саранмичид ХХК | 886 | 28.3 | | 0.1 | 886 | 28.2 | 0.79% |
| 16 | Моносцэцэг ХХК | 1253 | 41 | 2 | 0.1 | 1251 | 40.9 | 0.80% |
| 17 | Собц ХХК | 1994 | 51.4 | 1 | 0.2 | 1993 | 51.3 | 1.11% |
| 18 | Хутаг тэмүүлэл ХХК | 4915 | 149.4 | 5 | 0.2 | 4910 | 149.2 | 1.22% |
| 19 | Зууннаст ХХК | 1326 | 43.8 | 5 | 0.3 | 1321 | 43.6 | 1.60% |
| 20 | Сансар фарм ХХК | 218 | 6.9 | 4 | 0.3 | 214 | 6.6 | 1.62% |
| 21 | Шилмэлцэцэг ХХК | 1287 | 41.3 | 5 | 0.3 | 1282 | 41 | 1.86% |
| 22 | Бодьбүрэг ХХК | 742 | 26 | 10 | 0.3 | 732 | 25.7 | 1.87% |
| 23 | Шинэ тун ХХК | 879 | 57.6 | 7 | 0.4 | 872 | 57.2 | 2.65% |
| 24 | Мөнгөн тун ХХК | 1110 | 57 | | 0.5 | 1110 | 56.5 | 2.92% |
| 25 | Буман жор ХХК | 1572 | 54.3 | 11 | 0.5 | 1561 | 53.7 | 3.12% |
| 26 | Уянга Хулст | 2371 | 80.1 | 5 | 0.7 | 2366 | 79.4 | 4.24% |
| 27 | Сэлэнгэ-Анар ХХК | 3783 | 116.2 | 5 | 0.8 | 3778 | 115.4 | 4.77% |
| 28 | СХМ | 16713 | 293 | 19 | 0.9 | 16694 | 292.1 | 5.44% |
| 29 | Эгийн далай ХХК | 2127 | 80.2 | 4 | 1.5 | 2123 | 78.7 | 9.07% |
| 30 | Тэмээн хөх ХХК | 1861 | 52.8 | 2 | 1.6 | 1859 | 51.2 | 9.68% |
| 31 | Баяннуур -эм ХХК | 1304 | 30.9 | 30 | 1.9 | 1274 | 29 | 11.52 % |
| 32 | Элгэн бугат ХХК | 782 | 28.4 | 33 | 2.6 | 749 | 25.8 | 15.39 % |
| | **Энгийн эм нийт дүн** | **64187** | **1,681.10** | **152** | **13.8** | **70,109** | **1,667.40** | **0.82%** |

*Хавсралт 4*

## АЙМГИЙН ЭМД-Д ХАМРАГСДЫН МЭДЭЭЛЭЛ

| Үзүүлэлт | 2020 он | | | 2021 он | | | 2022 он | | | Төлөвлөгөөний харьцуулалт/2020 оныг суурь оноор авав/ | | Гүйцэтгэл /2020 оныг суурь оноор авав/ | | Гүйцэтгэлийн харьцуулалт /2020 оныг суурь оноор авав/ | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Хамрагдалт | Хамралтын хувь | Төлөвлөгөө | Хамрагдалт | Хамралтын хувь | Төлөвлөгөө | Хамрагдалт | Хамралтын хувь | Хамрагдалт | Хамралтын хувь | Хамрагдалт | Хамралтын хувь | Хамрагдалт | Хамралтын хувь |
| Хувиараа хөдөлмөр эрхлэгч | 2,900 | 1,447 | 49.9 | 2,900 | 815 | 28.1 | 2,610 | 1,100 | 42.1 | (290) | -10.0 | (632) | -43.7 | 285 | 35.0 |
| Малчин | 8,600 | 3,747 | 43.6 | 8,600 | 3,040 | 35.3 | 6,900 | 2,919 | 42.3 | (1,700) | -19.8 | (707) | -18.9 | (121) | -4.0 |
| Оюутан, суралцагч | 1,100 | 831 | 75.5 | 1,100 | 456 | 41.5 | 1,100 | 269 | 24.5 | - | 0.0 | (375) | -45.1 | (187) | -41.0 |
| Нийт | 12,600 | 6,025 | 47.8 | 12,600 | 4,311 | 34.2 | 10,610 | 4,288 | 40.4 | (1,990) | -15.8 | (1,714) | -28.4 | (23) | -0.5 |

*Хавсралт 5*

## *НЭХЭМЖЛЭХИЙН ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ГОМДОЛ ХҮСЭЛТ /НЭГДСЭН ЭМНЭЛЭГ/*

*/төгрөгөөр/*

| № | Огноо | Дугаар | Хамрах хугацаа | Тусламж үйлчилгээ авагчийн тоо | Нэхэмжилсэн, хүлээн зөвшөөрөөгүй дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 7/20/2022 | 01/321 | 2022/05/26-2022/07/08 | 4 | 6,966,000.00 |
| 2 | 8/8/2022 | 01/356 | 2022/06/11-2022/08/01 | 21 | 6,478,900.00 |
| 3 | 4/13/2022 | 01/159 | 3/14/2022 | 1 | |
| 4 | 5/25/2022 | 01/232 | 2022-04 | 3 | |
| 5 | 5/25/2022 | 01/233 | 2022-04 | 14 | 5,288,000.00 |
| 6 | 10/5/2022 | 02/440 | 2022-6.7 | 19 | 10,160,010.00 |
| 7 | 10/5/2022 | 02/437 | 2022-9 | 1 | |
| 8 | 12/22/2022 | 01/591 | 2022/11/17-2022/11/28 | 1 | |
| Нийт | | | | 64 | 28,892,910.00 |

-oOo-

Хавсралт 3

## Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

**Аудитын нэр:** Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө

**Аудитын код:** БУА-2023/19-4-ШТА-ГА

**Байгууллагын нэр:** Булган аймаг дахь Төрийн аудитын газар

| № | Аудитын чиглэл, асуулт | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн (мянган төгрөг) | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Гаргасан шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 3 | 4 | 5 | 8 | 9 |
| 1 | А.Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдаж байна уу? | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гэрээнд тухайн хүчин чадлын хэмжээг тусгасан ч гүйцэтгэлийг буюу гэрээг дүгнэхэд тухайн үзүүлэлтийг харгалзан үзээгүй, тооцоолоогүйгээс Тухайлбал: Баатарван сувиллын 2021 оны 7 дугаар сард 6, 8 дугаар сард 872, 9 дүгээр сард 350 ор хоног, 2022 оны 7 сард 370 ор хоногоор илүү гүйцэтгэлтэй байна. | 0.0 | Албан шаардлага өгөх | Зөвшөөрсөн | Албан шаардлага өгөх |
| 2 | | Хангал сумын ЭМТ-ийн 2022 оны 1 дүгээр сард ковид, хэвтэн эмчлүүлсэн 21 иргэний 29,400.0 мянган төгрөгийн баталгаажуулах хуудасны нэхэмжлэлд хүргүүлсэн албан тоот, нэрсийн жагсаалтгүй, Орхон сум ЭМТ-ын 4-8 дугаар сарын санхүүжилт 9,536.9 мянган төгрөгийг статистик эмчүйгээс нэхэмжлэл үүсгээгүй байна. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 05 дугаар тогтоолоор төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга журам шинэчлэн баталсан байна. Батлагдсан тогтоолыг 4, 5, 6, 7 саруудад мөрдөж ажиллаагүйгээс ЭМДС-гаас бүрэн санхүүжилт аваагүй, программд шивж оруулаагүй, алдаатай мэдээлэл оруулсан, даатгалгүй иргэн, онош тохирохгүй шалтгаанаар 2021, 2022 онд санхүүжилтийг бүрэн авч чадаагүй байна. | 2,481,847.5 | Зөвлөмж өгөх | Зөвшөөрсөн | Зөвлөмж өгөх |
| 3 | | Булган аймгийн ЭМДХ нь батлагдсан орон тооноос чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн зэрэг 2 орон тоо дутуу ажиллаж байна. | 0.0 | Зөвлөмж өгөх | Зөвшөөрсөн | Зөвлөмж өгөх |
| 4 | Б.2.Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн салбарт тодорхой ахиц дэвшил гарч байна уу? | Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд тусламж үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэхээр заасан боловч үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар үр дүнтэй ажил зохион байгуулаагүй, ЭМДХ, НДХ-ийн хамтын ажиллагаа хангалтгүй байна. | 0.0 | Зөвлөмж өгөх | Зөвшөөрсөн | Зөвлөмж өгөх |
| 5 | | Сэлэнгэ сумын ЭМТ-д 2021 оны 9 дүгээр сард ковид-19 халдвараар өвчилж хэвтэн эмчлүүлсэн өвчтөний жагсаалтад хэвтэн эмчлүүлээгүй 5 даатгуулагчийн мэдээллийг тус тус оруулж 4,900,000.0 төгрөгийн санхүүжилт авсан байна. | 4,900.0 | Төлбөрийн акт тогтоох | Зөвшөөрсөн | Төлбөрийн акт тогтоох |
| 6 | | Бугат сумын ЭМТ-д 2022 оны 2 дугаар сард ковид-19 халдвараар өвчилж хэвтэн эмчлүүлсэн өвчтөний жагсаалтад хэвтэн эмчлүүлээгүй 5 даатгуулагчийн мэдээллийг тус тус оруулж 4,900,000.0 төгрөгийн санхүүжилт авсан байна. | 4,900.0 | Төлбөрийн акт тогтоох | Зөвшөөрсөн | Төлбөрийн акт тогтоох |
| 7 | Б 3. Эрүүл мэндийн даатгалын салбарын хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагаа үр нөлөөтэй байна уу | Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/60 дугаар тушаалаар "Эрүүл мэндийн байгууллага дээр очиж хийх хяналт, шалгалтын журам" батлагдсантай холбоотойгоор эрүүл мэндийн байгууллага дээр хийсэн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. | 0.0 | Зөвлөмж өгөх | Зөвшөөрсөн | Зөвлөмж өгөх |
| 8 | | ЭМДЕГ-н даргын 2021 оны А/98 тоот тушаалаар батлагдсан "Нэхэмжлэлийн хяналт хийх журам"-ын дагуу эрүүл мэндийн байгууллагын нэхэмжлэлд хяналт хийсэн тайланг хавсралт-9-р гаргаж албан ёсны цахим хаягаас илгээдэггүй, журмын дагуу хянаж хассан нэхэмжлэхийн шалтгаан тайлбарыг ЭМДЕГ-т хянагдах болсонтой холбоотойгоор ЭМБ-уудад тухай бүр хүргүүлээгүй байна. | 0.0 | Албан шаардлага өгөх | Зөвшөөрсөн | Албан шаардлага өгөх |
| | Нийт дүн | | 2,491,651.5 | | | |

Бэлтгэсэн:

Аудитор А.Сувдаа

Аудитор Б.Золжаргал

Аудитор Б.Энхтөр

Ахлах аудитор Д.Анхбаяр

Анхан шатанд хянасан:
Менежер Ж.Энхцоодол

Хоёр дахь шатанд хянасан:
Дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ

Огноо:

Огноо:

Огноо:

Танилцаж зөвшөөрсөн:

ЭМДХ-ийн дарга Б.Ариунболд

Мэргэжилтэн Б.Чулуунчимэг

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ... БУЛГАН АЙМАГ ХТҮ7032 ☏ 6263305

6317144798 ... 3190269

**БУЛГАН АЙМГИЙН**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 05 сарын 19 өдөр Дугаар 01/206 Булган сум

А0670663 АТГ-2023/119-ШТА/ГА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын газрын даргын хянаж ирүүлсэн "Төлбөрийг баталгаажуулах хуудас" хүлээж авснаас хойш ажлын 3 хоногт багтаан төлбөрийг гүйцэтгэдэггүй, гүйцэтгээгүй төлбөрийн хэмжээ "Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ"-ний 4.1-д заасан хязгаарт хүрдэггүй учир хариуцлага тооцож алданги төлдөггүй, нэхэмжлэлд хяналт хийсэн тайланг хавсралт-9-р маягтаар гаргаж албан ёсны цахим хаягаас илгээдэггүй байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.14 "даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг нэхэмжлэх, түүнийг хянах, төлбөр тооцоог гүйцэтгэх, маргааны шийдвэрлэх журмыг батлах", Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/98 дугаар тушаалаар батлагдсан "нэхэмжлэлийн хяналт хийх журам"-ын 3.5.1, 5.3, 5.4 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. "Нэхэмжлэлийн хяналт хийх журам"-ын дагуу хяналтыг хийж нэхэмжилсэн дүнгээс хасагдсан шалтгаан тайлбарыг бүрэн бичиж, тайланг ЭМБ-д хүргүүлж байх, биелэлтийг 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт[2] ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомж, журмыг хэрэгжүүлж ажиллахыг Булган аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга

[2] Булган аймаг Булган сум 5-р баг аймгийн ЗДТГ-ийн байр 4 давхар 403 тоот өрөө, утас-70342716

0060406бС

(Б.Ариунболд), чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн (Б.Чулуунчимэг) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.ЭРДЭНЭ

МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТОР Б.ЗОЛЖАРГАЛ

6317144798
ГЮА0048 3190269

2 Булган аймаг Булган сум 5-р баг аймгийн ЗДТГ-ийн байр 4 давхар 403 тоот өрөө, утас-70342716

**БУЛГАН АЙМГИЙН**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 05 сарын 19 өдөр Дугаар 02/207 Булган сум

Д06702252 БУА-2023/19-4-ИТА-ГА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө"-д гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах гэрээнд Хутаг-Өндөр сумын "Баатарван" сувиллын хүчин чадлын хэмжээг тусгасан ч гүйцэтгэлийг буюу гэрээг дүгнэхэд тухайн үзүүлэлтийг харгалзан үзээгүй, тооцоолоогүйгээс 2021 оны 7 дугаар сард 6, 8 дугаар сард 872, 9 дүгээр сард 350, 2022 оны 7 сард 370 ор хоногоор илүү гүйцэтгэлтэй байна.

Энэ нь ЭМДЕГ-ын даргын 2018 оны 141 дугаар тушаалаар батлагдсан "Даатгалын гэрээ дүгнэх журам"-ын 4, 2022 оны А/61 дүгээр тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээний биелэлтийг үнэлэх, урамшуулал олгох журам"-ын 3.1, БУ 03-2/20 гэрээний 6.2.3-т "Батлагдсан хүчин чадлаас давсан, шаардлагагүй тусламж үйлчилгээг даатгуулагчдад үзүүлсэн тохиолдолд" гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлийг таслаан зогсоож биелэлтийг 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газар[2]-т ирүүлэх.

[2] Булган аймаг Булган сум 5-р баг аймгийн ЗДТГ-ийн байр 4 давхар 403 тоот өрөө, утас-70342495

006040671

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль журмыг хэрэгжүүлж ажиллахыг Булган аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга Б.Ариунболд, чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн Б.Чулуунчимэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.ЭРДЭНЭ

АУДИТЫН МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТОР А.СУВДАА

6317144798
ГЮА0048 3190269

[2] Булган аймаг Булган сум 5-р баг аймгийн ЗДТГ-ийн байр 4 давхар 403 тоот өрөө, утас-70342495

**БУЛГАН АЙМГИЙН**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**ТӨЛБӨРИЙН АКТ**

2023 оны 05 дугаар сарын 19 Дугаар 01/177 Булган сум

БУА-2023/19-4-ШТА-ГА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ковид-19 халдвараар өвчилж хэвтэн эмчлүүлсэн иргэдийн ЭМДХ-д нэхэмжилсэн дүн, хэвтэж эмчлүүлсэн эсэхийг түүвэрлэн тулгаж тодруулахад хэвтэн эмчлүүлээгүй 5 даатгуулагчийн мэдээллийг оруулж 4,900,000.0 төгрөгийн санхүүжилт авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13.1-д "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага дараах эрх, үүрэгтэй", 13.1.6-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх", 16.1-д "Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ", 16.1.5-д "даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон зардлын төлбөрт хяналт тавьж, энэ хуулийн 14.8.7-д заасан журамд тусгагдсан шалгуур хангасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төлбөр олгох", 23.2.3-д "эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг энэ хуулийн 14.8.7-д заасан журмын дагуу цахим болон бусад хэлбэрээр хэрэгжүүлэх", Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Чанар, төлбөрийн хяналтын журам"-ын 3.7.3-д "ЭМБ нь үзүүлсэн тусламж, үйлчилгээний төлбөрийг нэхэмжлэхдээ бодит байдлаас давуулан илүү өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээний код ашиглан нэхэмжилж код ахиулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн

[1] Булган аймаг Булган сум 5-р баг аймгийн ЗДТГ-ийн байр 4 давхар 403 тоот өрөө, утас-70342495

006050595

орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Эрүүл мэндийн даатгалын сангаас авсан Ковид-19 халдвараар хэвтэн эмчлүүлээгүй хавсралт дахь иргэдийн тусламж үйлчилгээний зардлыг ЭМДЕГ-н эрүүл мэндийн даатгалын сангийн 100900020080 (регистрийн дугаар-62633050 тоот дансанд Бугат сумын ЭМТ-ийн дарга (Ж.Сэргэлэн), нягтлан бодогч (У.Энхзаяа), нараар төлүүлэх;

2.Актын биелэлтийг 2023 оны 10 дугаар сарын 05-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт[1] иргүүлэхийг Булган аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга Б.Ариунболд, чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн Б.Чулуунчимэг нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.ЭРДЭНЭ
МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ
АХЛАХ АУДИТОР Д.АНХБАЯР
АУДИТОР Б.ЭНХТӨР
А.СУВДАА
Б.ЗОЛЖАРГАЛ

[1] Булган аймаг Булган сум 5-р баг аймгийн ЗДТГ-ийн байр 4 давхар 403 тоот өрөө, утас-70342495

Дарга, Тэргүүлэх аудиторын 22 оны 05
сарын 19 өдрийн 01 тоот төлбөрийн
актын хавсралт

6317144793
ГЮА0048 3190269

## Хэвтэн эмчлүүлээгүй иргэдийн жагсаалт

| № | Овог | Нэр | Регистрийн дугаар | Төлбөрийн актын дүн | Зөрчлийн утга |
|---|---|---|---|---|---|
| **Бугат сумын ЭМТ 2022 оны 2 дугаар сар** | | | | | |
| 1 | Дамба | Баярцэнгэл | ГБ58071132 | 980,000.00 | Гэрээр эмчлүүлсэн |
| 2 | Дагвадорж | Болор-Эрдэнэ | ГЮ08242709 | 980,000.00 | Хэвтэн эмчлүүлээгүй, эм өөрөө авсан |
| 3 | Батмөнх | Түмэнжаргал | ГЕ96083006 | 980,000.00 | 8-р сар батладаж эмчлүүлсэн. 2-р сард төлбөр нэхэмжилж |
| 4 | Эрхэмбаяр | Жаргалбаяр | ГБ19311311 | 980,000.00 | |
| 5 | Бямбасүрэн | Мөнхжаргал | ГБ54041201 | 980,000.00 | 2 хоноод өөр эмнэлэгт шилжин хэвтэж эмчлүүлсэн |
| **Нийт дүн** | | | | **4,900,000.00** | |

-оОо-

**БУЛГАН АЙМГИЙН**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**ТӨЛБӨРИЙН АКТ**

2023 оны 05 дугаар сарын 19　　　　Дугаар 02/178　　　　Булган сум

БУА-2023/19-4-ИТН-ТА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ковид-19 халдвараар өвчилж хэвтэн эмчлүүлсэн иргэдийн ЭМДХ-д нэхэмжилсэн дүн, хэвтэж эмчлүүлсэн эсэхийг түүвэрлэн тулгаж тодруулахад хэвтэн эмчлүүлээгүй 5 даатгуулагчийн мэдээллийг оруулж 4,900,000.0 төгрөгийн санхүүжилт авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13.1-д "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага дараах эрх, үүрэгтэй", 13.1.6-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх", 16.1-д "Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ", 16.1.5-д "даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон зардлын төлбөрт хяналт тавьж, энэ хуулийн 14.8.7-д заасан журамд тусгагдсан шалгуур хангасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төлбөр олгох", 23.2.3-д "эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг энэ хуулийн 14.8.7-д заасан журмын дагуу цахим болон бусад хэлбэрээр хэрэгжүүлэх", Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Чанар, төлбөрийн хяналтын журам"-ын 3.7.3-д "ЭМБ нь үзүүлсэн тусламж, үйлчилгээний төлбөрийг нэхэмжлэхдээ бодит байдлаас давуулан илүү өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээний код ашиглан нэхэмжилж код ахиулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн

[1] Булган аймаг Булган сум 5-р баг аймгийн ЗДТГ-ийн байр 4 давхар 403 тоот өрөө, утас-70342495

006050605

орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Эрүүл мэндийн даатгалын сангаас авсан Ковид-19 халдвараар хэвтэн эмчлүүлээгүй хавсралт дахь иргэдийн тусламж үйлчилгээний зардлыг ЭМДЕГ-н эрүүл мэндийн даатгалын сангийн 100900020080 (регистрийн дугаар-62633050 тоот дансанд Сэлэнгэ сумын ЭМТ-ийн дарга (Ө.Бужинлхам), нягтлан бодогч (Г.Ариунцэцэг) нараар төлүүлэх;

2.Актын биелэлтийг 2023 оны 10 дугаар сарын 05-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт[1] ирүүлэхийг Булган аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга Б.Ариунболд, чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн Б.Чулуунчимэг нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Б.ЭРДЭНЭ
МЕНЕЖЕР — Ж.ЭНХЦООДОЛ
АХЛАХ АУДИТОР — Д.АНХБАЯР
АУДИТОР — Б.ЭНХТӨР
А.СУВДАА
Б.ЗОЛЖАРГАЛ

6317144798
ГЮА0048 9190268

[1] Булган аймаг Булган сум 5-р баг аймгийн ЗДТГ-ийн байр 4 давхар 403 тоот өрөө, утас-70342495

Дарга, Тэргүүлэх аудиторын 2023 оны 02 сарын 10 өдрийн 01/78 тоот төлбөрийн актын хавсралт

6317144793
ГЮА0048 3190269

# Хэвтэн эмчлүүлээгүй иргэдийн жагсаалт

| № | Овог | Нэр | Регистрийн дугаар | Төлбөрийн актын дүн | Зөрчлийн утга |
|---|---|---|---|---|---|
| **Сэлэнгэ сумын ЭМТ 2021 оны 9 дүгээр сар** | | | | | |
| 1 | Доржбал | Буяннэмэх | ГИ52072311 | 980,000.00 | Ковид тусаагүй, эмчлүүлээгүй |
| 2 | Хишигбадрах | Эрдэнэчимэг | ГИ87063003 | 980,000.00 | Гэрээр эмчлүүлсэн |
| 3 | Мандах | Бат | ГИ87021014 | 980,000.00 | |
| 4 | Бат | Намуун | ГИ10303141 | 980,000.00 | |
| 5 | Бат | Дөлгөөн | ГИ09260405 | 980,000.00 | |
| **Нийт дүн** | | | | **4,900,000.00** | |

-oOo-

**БУЛГАН АЙМГИЙН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН**
**ХЭЛТЭС**

Булган сум, Булган аймаг, 63080
Утас/Факс: (976) 7034 0408,
Цахим шуудан: bulgan@emd.gov.mn,
Цахим хуудас: www.emd.gov.mn


2023.05.19 № 15/25

танай ______________-ны №______________-т

АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас ирүүлсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС
БУЛГАН АЙМАГ
ХТУ7032 6263305

ДАРГА Б.АРИУНБОЛД

/D-A5 toot-2023/

Хавсралт 3

**Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт**

**Аудитын нэр:** Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө

**Аудитын код:** БУА-2023/19-4-ШТА-ГА

**Байгууллагын нэр:** Булган аймаг дахь Төрийн аудитын газар

| № | Аудитын чиглэл, асуулт | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн (мянган төгрөг) | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Гаргасан шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 3 | 4 | 5 | 8 | 9 |
| 1 | | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гэрээнд тухайн хүчин чадлын хэмжээг тусгасан ч гүйцэтгэлийг буюу гэрээг дүгнэхэд тухайн үзүүлэлтийг харгалзан үзээгүй, тооцоолоогүйгээс Тухайлбал: Баатарван сувиллын 2021 оны 7 дугаар сард 6, 8 дугаар сард 872, 9 дүгээр сард 350 ор хоног, 2022 оны 7 сард 370 ор хоногоор илүү гүйцэтгэлтэй байна. | - | Албан шаардлага өгөх | Зөвшөөрөв | |
| 2 | | ЭМБ-д баталгаажуулах хуудсаарх олгохоор тооцсон дүн, шилжүүлгээр олгосон дүнгийн хоорондын зөрүүг авлага/ өглөгөөр тусгаж тооцоо үлдэгдлийн баталгаагаар үнэн зөв хийгээгүй. Тухайлбал Баатарван сувилал 2021 онд 520,866.3 мянган төгрөгийн тусламж үйлчилгээний зардлыг нэхэмжилснээс шаардлагад нийцээгүй 51,316.3 мянган төгрөг хасагдаж, 469,550.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсонд ЭМДЕГ-аас 2021 онд 467,300.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож 2,250.0 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгожээ. | 2 250,00 | Албан шаардлага өгөх | Уг албан шаардлагад тусгасан ЭДМЕГ-аас ирүүлсэн тоо зөрүүтэй байна. 2021 онд Баатарван амралт сувиллын газар 523,116,342 төгрөг нэхэмжилж эмчийн хасагдлаар 51,316,342 төгрөг хасагдаж 471,800,000 төгрөг олгохоор тооцсон боловч ЭМДЕГ-аас 441,550,000 төгрөг олгож 30,250,000 төгрөгний өртэй байна. Тус хэлтсийн 2021, 2022 оны Санхүүгийн жилийн эцсийн тайлангаар тухайн санхүүжилтүүд таарч байгаа тул уг албан шаардлагаар үүссэн 2,250,000 төгрөгийг хүлээн зөвшөөрөхгүй байгуу тул уг албан шаардлагыг хасуулах саналтай байна. <u>Жич. Хавсралтаар ЭМДС-н хэлтсийн 2021, 2022 оны санхүүгийн тайлан/Санхүүгийн тайлан олон хуудас гарч байгаа тул Баатарван рашаан сувилал орсон хэсгийг тасдаж хэвлэв./, ЭМДЕГаас 2023,05,22-нд авсан санхүүжилтийн тооцоог хавсаргав.</u> | |
| 3 | | Хангал сумын ЭМТ-ийн 2022 оны 1 дүгээр сард ковид, хэвтэн эмчлүүлсэн 21 иргэний 29,400.0 мянган төгрөгийн баталгаажуулах хуудасны нэхэмжлэлд хүргүүлсэн албан тоот, нэрсийн жагсаалтгүй, Орхон сум ЭМТ-ын 4-8 дугаар сарын санхүүжилт 9,536.9 мянган төгрөгийг статистик эмчүйгээс нэхэмжлэл үүсгээгүй байна. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 05 дугаар тогтоолоор төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга журам шинэчлэн баталсан байна. Батлагдсан тогтоолыг 4, 5, 6, 7 саруудад мөрдөж ажиллаагүйгээс ЭМДС-гаас бүрэн санхүүжилт аваагүй, программд шивж оруулаагүй, алдаатай мэдээлэл оруулсан, даатгалгүй иргэн, онош тохирохгүй шалтгаанаар 2021, 2022 онд санхүүжилтийг бүрэн авч чадаагүй байна. | 2 481 847,50 | Зөвлөмж өгөх | Зөвшөөрөв | |
| 4 | | Булган аймгийн ЭМДХ нь батлагдсан орон тооноос Чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн зэрэг 2 орон тоо дутуу ажиллаж байна. | - | Зөвлөмж өгөх | Зөвшөөрөв | |
| 5 | Б.2 Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн салбарт тодорхой ахиц дэвшил гарч байна уу? | Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд тусламж үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэхээр заасан боловч үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар үр дүнтэй ажил зохион байгуулаагүй, ЭМДХ, НДХ-ийн хамтын ажиллагаа хангалттгүй байна | - | Зөвлөмж өгөх | ТҮс хэлтэс нь ЭМДЕГ-н даргын тушаалаар 4 хүний бүтэц орон тоотой ЭМДСангийн орлогын төлөвлөгөөг сумдад НДХ-н байцаагч нар хангаж ажилладаг. Мөн ЭМДЕГ болон НДЕГ-н даргын хамтран ажиллах гэрээний дагуу тус 2 байгууллага хамтарч Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх ажлуудыг хамтран хийдэг тул уг зөвлөмжийг хасах саналтай байна. | |
| 6 | | Нэхэмжлэлийн хяналттай холбоотой ЭМБ-аас ирүүлсэн санал, гомдлыг ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/98 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу бүрэн шийдвэрлээгүй | - | Албан шаардлага өгөх | ЭМДЕГ-н даргын 2021 оны А/98 дугаар тушаал, 2022 оны А/139 дүгээр тушаалын дагуу гэрээт ЭМБ-уудаас нэхэмжлэлийн хяналттай холбоотой ирүүлсэн гомдол саналыг дээрхи 2 тушаалаар батлагдсан журмын дагуу гэрээт ЭМБ-дад хүргэх ажлыг зохион байгуулж байна. Мөн нэхэмжлэлийн хяналтаар илэрсэн алдаа дутагдлыг 2023 оны 03 дугаар сараас эхлэн тухайн байгууллагуудад Улсын ахлах байфаагчийн зөвлөмж хүргүүлэн ажилладаг болсон тул уг албан шаардлагыг зөвлөмжөөр авах саналтай байна. | |
| 7 | Б 3. Эрүүл мэндийн даатгалын салбарын хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагаа үр нөлөөтэй байна уу | Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/60 дугаар тушаалаар "Эрүүл мэндийн байгууллага дээр очиж хийх хяналт, шалгалтын журам" батлагдсантай холбоотойгоор эрүүл мэндийн байгууллага дээр хийсэн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. | - | Зөвлөмж өгөх | Зөвшөөрөв | |
| 8 | | ЭМДЕГ-н даргын 2021 оны А/98 тоот тушаалаар батлагдсан "Нэхэмжлэлийн хяналт хийх журам"-ын дагуу эрүүл мэндийн байгууллагын нэхэмжлэлд хяналт хийсэн тайланг хавсралт-9-р гаргаж албан ёсны цахим хаягаас илгээдэггүй, журмын дагуу хянаж хассан нэхэмжлэхийн шалтгаан тайлбарыг ЭМДЕГ-т хянагдах болсонтой холбоотойгоор ЭМБ-үүдэд тухай бүр хүргүүлээгүй байна | - | Албан шаардлага өгөх | Зөвшөөрөв | |
| | Нийт дүн | | 2 484 101,50 | | | |

Бэлтгэсэн
Аудитор А Сувдаа
Аудитор Б Золжаргал
Аудитор Б Энхтөр
Ахлах аудитор Д Анхбаяр
Огноо:

Анхан шатанд хянасан
Менежер Ж Энхцоодол
Огноо:

Хоёр дахь шатанд хянасан
Дарга, тэргүүлэх аудитор Б Эрдэнэ
Огноо:

Танилцаж зөвшөөрсөн:
ЭМДХ-ийн дарга Б Ариунболд
Мэргэжилтэн Б Чулуунчимэг

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ... БУЛГАН АЙМАГ ХТҮ032 ☏ 6263305
ГЮА0048 3190269